



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

ГАЗРЫН ТОСНЫ САЛБАР: САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮР НӨЛӨӨ

Судлаач: Б.Урангоо (LL.M)
Туслах судлаач: М.Сэлэнгэ

Улаанбаатар хот
2024 он

ННА 65
ДАА 330
У-457

© Нээлттэй Нийгэм Форум

978-9919-9083-9-3

Судалгааны хүрээнд гаргасан дүгнэлт, санал нь зөвхөн судлаачдын үзэл бодол бөгөөд Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

“Би Си Ай” ХХК-д эхийг бэлтгэж, хэвлэв.

АГУУЛГА

УДИРТГАЛ	7
1. Судалгааны зорилго, зорилт.....	8
2. Судалгааны хамрах хүрээ, арга зүй	10
БҮЛЭГ 1. ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ	11
1.1. Газрын тосны салбарын эрх зүйн орчин ба Бүтээгдэхүүн хуваах гэрээ	11
1.2. Газрын тосны санхүүгийн хяналт, шалгалтын үе шат.....	15
БҮЛЭГ 2. ГАЗРЫН ТОСНЫ САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮР НӨЛӨӨ	18
2.1. Газрын тосны хайгуулын үе шатны санхүүгийн хяналт шалгалт, баталгаажуулалт	18
2.2. Газрын тосны олборлолтын үе шатны санхүүгийн хяналт шалгалт, баталгаажуулалт	25
ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	38
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	41
ХАВСРАЛТ	43

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ:

АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
БХГ	Бүтээгдэхүүн хуваах гэрээ
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
УУХҮ-ийн сайд	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
ҮАГ	Үндэсний аудитын газар

Өмнөх үг

Монгол Улсад газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагааны суурь тавигдаад даруй 20 гаруй жил болж байна. Газрын тосны хайгуулын анхны бүтээгдэхүүн хуваах гэрээ 1993 онд байгуулагдаж байсан бол одоогийн байдлаар нийт 25 талбайд 21 гэрээлэгч үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс 2 компани хайгуулын үе шатыг дуусгаж, газрын тосны олборлолт явуулж, газрын тос боловсруулах үйлдвэрийн суурь тавигдаж эхлэлээ.

Эдийн засгийн хувьд стратегийн ач холбогдолтой энэ салбарт тавих хяналт, тэр дундаа санхүүгийн хяналт шалгалт нь гэрээний талуудын хувааж авах газрын тосны хэмжээг үнэн зөв тодорхойлоход чухал ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулагчийн тухайн жилд оруулсан хөрөнгө оруулалт, төлөвлөгөө төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, өртөг нөхөгдөх болон нөхсөн зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогыг хэрхэн тооцсоноос хөрөнгө оруулагч болон Засгийн газарт бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу оногдох ашигт газрын тосны хэмжээ хамаарах тул санхүүгийн хяналт шалгалт нэн чухал билээ.

Иймд ННФ-аас газрын тосны гэрээлэгчийн үйл ажиллагаанд тавих санхүүгийн хяналт шалгалтын хэрэгжилт, үр нөлөөг сайжруулахад хувь нэмэр оруулах зорилгоор Газрын тосны салбарын хяналт, шалгалтын тогтолцоо, үр нөлөө судалгааг хийгээд байна. 2014 онд шинэчлэн батлагдсан Газрын тосны тухай хуулийн дагуу хэрэгжих учиртай санхүүгийн хяналт, шалгалттай холбоотой журмууд өнөөг хүртэл бүрэн гараагүй байгаа нь хяналт шалгалтын ажилд саад учруулж байна. Нийт 13 журам мөрдөгдөх ёстойгоос 2020 оны байдлаар 9 нь буюу 2015 онд гурав, 2017 онд хоёр, 2018 онд гурав, 2019 онд нэг журам тус тус батлагдсан байна.

Тэрчлэн газрын тосны хайгуулын үйл ажиллагаанд 2014-2019 онд хийгдсэн санхүүгийн аудитын зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, зөрчлүүд давтагдан гарсаар байна. Олборлолтын шатанд аудит хийх чиг үүрэг 2014 онд хуульчлагдсан хэдий ч дөнгөж 2018 оноос хэрэгжиж эхэлжээ. Ийнхүү аудитын дүгнэлт гараагүйтэй холбоотойгоор 2014-2019 оны байдлаар нийт олборлосон болон гэрээлэгчтэй хуваасан ашигт газрын тосны болон улсын төсөвт оруулсан орлогын хэмжээ үнэн зөв эсэхийг тогтоох боломжгүй байдал үүссэн зэрэг асуудлыг уг тайланд онцолжээ.

Газрын тосны салбарт санхүүгийн хяналт, шалгалт хийхэд тулгарч буй бэрхшээл, алдаа дутагдал, тэдгээрийг арилгахтай холбоотой зөвлөмжийг багтаасан энэхүү тайлан газрын тосны салбарын үр өгөөжийг дээшлүүлэхэд зохих хувь нэмэр оруулна гэдэгт найдаж байна.

Судалгааг хийж гүйцэтгэсэн судлаач Б.Урангоо үнэтэй санал зөвлөгөө өгч ажилласан ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер Д.Эрдэнэчимэг, Хэвлэлийн менежер Д.Балжид нарт талархал илэрхийлье.

Нээлттэй Нийгэм Форумын гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал

УДИРТГАЛ

Манай улсад газрын тосны эрэл, хайгуул, ашиглалт, олборлолтын үйл ажиллагаа уул уурхайн салбарын өсөлттэй уялдан эрчимжиж байна. Газрын тосны олборлолт, бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон түүний хангамжийн асуудал нь улс орны үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн тогтвортой өсөлт, нийгмийн хөгжил, бүс нутагт эзлэх байр суурьт чухал нөлөөтэй.

Монгол Улсын ашигт малтмалын нөөцийн санд нийт 333.789 сая тонн газрын тос бүртгэгдсэний 43.4 сая тонн нь ашиглалтын баталгаат нөөц юм.¹ Ашиглалтын баталгаат нөөц гэдэг нь тухайн орд газраас олборлох боломжтой техник, эдийн засгийн үндэслэл нь батлагдсан нөөцийг хэлнэ.

Олон улсад газрын тосны салбарын хөрөнгө оруулалтыг концессын гэрээ,² бүтээгдэхүүн хуваах гэрээ, үйлчилгээний гэрээ,³ эрсдэлийн үйлчилгээний⁴ гэрээгээр хийдэг бөгөөд манай улсын хувьд Бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ)-ний загварыг ашигладаг. БХГ нь хөрөнгө оруулагч эрсдэлээ хариуцан газрын тосны эрэл, хайгуул, ашиглалт, олборлолтын явцад гарсан зардал болон олборлолт, ашиглалтад оруулсан нийт хөрөнгө оруулалтыг олборлосон газрын тосноосоо нөхөж авах үндсэн нөхцөлтэй бөгөөд БХГ-ний талууд нь хөрөнгө оруулагч болон Засгийн газар байна.

Хөрөнгө оруулагчийн зорилго нь газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд гаргасан зардлаа газрын тосоор нөхөж авч ашигтай ажиллах явдал байдаг бол Засгийн газрын зорилго нь байгалийн баялгаа ашиглуулсны төлбөр хураамжийг гэрээнд заасан хэмжээгээр авахаас гадна хөрөнгө оруулагчийн зардлыг буцаахад зориулагдсан газрын тос (өртөгт)-ноос бусад тосыг өөртөө

1 <https://mrpm.gov.mn/> Ашигт малтмал, газрын тосны газрын цахим хуудас.

2 Концессын гэрээ-Баталгаажсан ажлын хөтөлбөр, эсхүл мөнгөн урамшуулал төлсний үндсэн дээр байгуулдаг, хөрөнгө оруулагч хайгуул, ашиглалтын онцгой эрхтэй, эрсдэл болон зардлыг хариуцдаг гэрээ.

3 Үйлчилгээний гэрээ-Засгийн газар тодорхой ажил, үүргийг гүйцэтгүүлэхээр гадаадын компанитай байгуулдаг. Үйлчилгээний гэрээ нь цэвэр үйлчилгээний гэрээ, эрсдэлийн үйлчилгээний гэрээ гэсэн хоёр төрөлтэй ба эдгээрийг нэгтгэсэн холимог гэрээ бас байдаг. Гэрээний бусад төрлөөс ялгаатай нь зөвхөн тогтмол үнээр, эсвэл ашиг ба тогтмол үнээр тодорхойлогдсон эсэхээс шалтгаална.

4 Эрсдэлийн үйлчилгээний гэрээ-Цэвэр үйлчилгээний буюу компани нь газрын тосны ашиглалтын үйл ажиллагааны менежментийг Засгийн газарт хийж өгөх буюу техникийн зөвлөгөө өгөх, боловсон хүчнээр хангах, ашиглалтын менежмент, үйл ажиллагааны талаар тухайн улсын иргэдийг сургах, дадлагажуулах, олборлосон тосны хэмжээнд тохирох төлбөр төлөх, зарим тохиолдолд олборлосон тосныхоо тодорхой хэсгийг худалдан авах нэмэлт эрхтэй гэрээний төрөл.

авч захиран зарцуулахад чиглэнэ. Засгийн газрын энэхүү зорилго хангагдахад хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаанд тавих санхүүгийн хяналт, шалгалт нэн чухал.

Манай улс 2023 оны байдлаар **газрын тосны хэтийн төлөв бүхий** хайгуулын 33 талбай ялгаснаас 28 талбайд 31 гэрээлэгч Засгийн газартай БХГ байгуулсан байна.⁵

Анхны БХГ 1993 онд байгуулагдсан бөгөөд газрын тосны олборлолтын чиглэлээр дараах компаниуд үйл ажиллагаа явуулж,⁶ (Хүснэгт 1) 1996-2022 оны хооронд нийт 75.98 сая баррель буюу 10.28 сая тонн тос олборлож, 72.81 сая баррель буюу 9.85 сая тонн тосыг БНХАУ-д экспортолжээ. Газрын тосны орлогоос нийт 2.18 их наяд төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.⁷

Хүснэгт 1. Газрын тосны олборлолт явуулж буй компаниуд

д/д	Талбайн нэр	Гэрээлэгчийн нэр
1	Тосон-Уул (XIX)	Петрочайна дачин тамсаг ХХК
2	Тамсаг (XXI)	
3	(БХГ-97)	Доншен газрын тос (Монгол) ХХК
4	Матад (XX)	Петро Матад ХХК

Судалгааны зорилго, зорилт

Улс орон баялагтай байх, баялгаасаа үр ашиг хүртэх гэдэг нь тусдаа ойлголтууд юм. Ялангуяа манай улсын газрын тосны салбарт гадаадын хөрөнгө оруулалт давамгайлж байгаа одоогийн нөхцөлд БХГ-ний дагуу хөрөнгө оруулагч (Гэрээлэгч) нь тухайн жилд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа⁸ явуулахдаа гаргасан нийт хөрөнгө оруулалт, экспорт, борлуулалтын орлого, өртөг нөхөгдөх зардлаа⁹ үнэн зөв бүртгэж, тайлагнасан эсэхийг Засгийн газрын зүгээс хянах, уг хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн олон нийтэд ил тод, нээлттэй байх нь чухал юм.

5 Дэлгэрэнгүйг Хавсралт 1-ээс үзнэ үү.

6 2021 онд Ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд хүлээн авсан. Эх сурвалж: <https://mram.gov.mn/> Ашигт малтмал, газрын тосны газрын цахим хуудас.

7 Эх сурвалж: <https://mram.gov.mn/> Ашигт малтмал, газрын тосны газрын цахим хуудас.

8 Газрын тосны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6. "Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа" газрын тос, уламжлалт бус газрын тос эрэх, хайх, ашиглах, хадгалах, тээвэрлэх, борлуулах, татан буулгахтай холбогдсон үйл ажиллагааг ойлгоно.

9 Газрын тосны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.31."өртөг нөхөгдөх зардал" гэж хайгуул, бүтээн байгуулалт, үйл ажиллагаа, татан буулгалтын зардлын нийлбэрийг ойлгоно.

БХГ-ний хэрэгжилтэд хийх санхүүгийн хяналт шалгалт, баталгаажуулалтыг 2014 онд батлагдсан Газрын тосны тухай хуулийн (шинэчилсэн найруулга) дагуу дараах үе шаттайгаар гүйцэтгэж байна.

1-р үе шат: Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага буюу Ашигт малтмал, газрын тосны газар (АМГТГ) Гэрээлэгчийн санхүүгийн тайланг хянан шалгаж, дүгнэлт гарган төрийн аудитын байгууллагад хүргүүлэх,

2-р үе шат: Төрийн аудитын байгууллага АМГТГ-аас ирүүлсэн тайлан, дүгнэлтэд аудит хийж, баталгаажуулах.

Газрын тосны тухай хуульд 2020 онд орсон нэмэлт, өөрчлөлтөөр дээрх 2 үе шат бий болжээ. Үүнээс өмнө **2014–2019** онд батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу Гэрээлэгчийн хийж гүйцэтгэсэн ажил, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, хөрөнгө оруулалтын тайланд хийх санхүүгийн хяналт, шалгалт 1 үе шаттай буюу төрийн аудитын байгууллага хэрэгжүүлдэг (Газрын тосны тухай хуульд холбогдох байгууллагатай хамтран гэж заасан боловч Төрийн аудитын тухай хууль болон аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитыг хараат бусаар, бие даан, хөндлөнгийн байр сууринаас хэрэгжүүлдэг)¹⁰ байсныг дурдах нь зүйтэй.

Гэхдээ санхүүгийн хяналт шалгалт хэдэн үе шаттай байхаас үл хамааран үндсэн зорилго нь ЗГ-аас Гэрээлэгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, холбогдох хууль тогтоомж, БХГ-нд нийцэж буй эсэхийг жил бүр хянан баталгаажуулж, газрын тосны орлогыг үнэн зөв тооцон улсын төсөвт төвлөрүүлэх явдал юм. Санхүүгийн хяналт шалгалттай холбоотой төрийн байгууллагуудын чиг үүргийг хуулиар тодорхойлсон байдаг боловч одоогийн байдлаар түүний биелэлт газрын тосны хайгуулын салбарт хуанлийн 1-2 жилээр, олборлолтын салбарт даруй 3-5 жилээр хоцрогдолтой байгаа нь анхаарал татаж байна.

Иймд судалгааны зорилго, зорилтыг дараах байдлаар тодорхойлов.Үүнд:

- Газрын тосны салбарын санхүүгийн хяналт шалгалт буюу АМГТГ болон төрийн аудитын байгууллагын санхүүгийн хяналт шалгалт, аудитын төлөвлөлт болон гүйцэтгэл хоцорч буй шалтгааныг тодорхойлох.
- АМГТГ болон төрийн аудитын байгууллагаас хийх санхүүгийн хяналт шалгалт, аудитад баримталж байгаа хууль эрх зүйн орчин нийтлэг байхад

¹⁰ Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйл. Аудит хийх бүрэн эрх. 15.1.21.“Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр үйл ажиллагаа явуулж байгаа гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад аудит хийх”.

Гэрээлэгчийн үйл ажиллагаанд хийсэн дүгнэлт, өртөг нөхөх зардлын дүн яагаад өөр өөр гардгийн шалтгааныг судлах.

Судалгааны хамрах хүрээ, арга зүй

Судалгааг газрын тосны хайгуул, олборлолтын үе шатаар, Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаас хойших хугацааг хамруулан эрх зүйн орчин, БХГ-ний зохицуулалт, санхүүгийн хяналт шалгалтын үе шат, аудитын байгууллага болон АМГТГ-ын хуулиар хүлээсэн үүргийн гүйцэтгэл, үр дүнд тулгуурлан гүйцэтгэв.

Судалгаанд чанарын аргыг голчлон ашигласан бөгөөд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ), Сангийн яам, АМГТГ, Үндэсний аудитын газар (ҮАГ), Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн сан, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга зэрэг байгууллагын цахим хуудас, www.shilendans.gov.mn болон бусад эх сурвалжийг дараах байдлаар ашигласан болно. Үүнд:

1. Газрын тосны хайгуул, олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа гэрээлэгчдийн БХГ-г Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн сан (www.iltodgeree.mn)-аас татан авч судлах,
2. Газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа гэрээлэгчдийн 2015-2021 оны болон олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа гэрээлэгчдийн 2014-2021 оны хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлыг хянаж, баталгаажуулсан аудитын тайлангууд, АМГТГ, Сангийн яам, УУХҮЯ зэрэг байгууллагуудаас мэдээлэл авч нэгтгэх,
3. ҮАГ-ын аудитын баг, АМГТГ-ын холбогдох мэргэжилтнүүдтэй уулзалт хийж, тайлбар тодруулга авах

БҮЛЭГ 1. ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ

1.1 Газрын тосны салбарын эрх зүйн орчин ба Бүтээгдэхүүн хуваах гэрээ

Газрын тосны салбарын харилцааг БНМАУ-ын Газрын тосны тухай хууль,¹¹ БНМАУ-ын Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журам болон хөрөнгө оруулагч нартай байгуулсан БХГ-ээр зохицуулж байсан бөгөөд 2014 онд Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан.

Газрын тосны тухай хуулиар Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тос, уламжлалт бус газрын тосыг¹² эрх, хайх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулах бөгөөд газрын тостой холбоотой үйл ажиллагааг хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн үндсэн дээр гүйцэтгэх, тусгай зөвшөөрлийг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгох, хайгуулын болон ашиглалтын талбайд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах, тусгай зөвшөөрөл эзэмшигч нь БХГ байгуулах, БХГ-ний загварыг Засгийн газар батлахаар зохицуулжээ. Мөн газрын тосны салбараас улсын төсөвт орох татварын орлогын зарим хэсгийг аймаг, нийслэл, сум, дүүргийн төсөвт хуваарилах, нутгийн удирдлагын байгууллагын газрын тос, уламжлалт бус газрын тостой холбоотой эрх, үүрэг, оролцоо болон газрын тосны тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчин, хөдөлмөр эрхлэлт, аюулгүй ажиллагаа болон тэдгээртэй холбоотой хүлээх үүрэг, зөрчсөн тохиолдолд ногдуулах хариуцлагыг тодорхойлсон байна.

Уг хуулийн бас нэг онцлог зохицуулалт бол Гэрээлэгчийн санхүү, хөрөнгө оруулалтын тайланд хяналт шалгалт хийх, баталгаажуулах асуудлыг эрх бүхий аудитын байгууллага тодорхой хугацаанд давтамжтайгаар хийж байх, энэ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө буюу 1991 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр батлагдсан Газрын тосны тухай хуулийн дагуу байгуулсан гэрээнд төлбөр, зардал, өртөг нөхөлт, бүтээгдэхүүн хуваалтыг тухайн гэрээнд заасан хувь, хэмжээгээр зохицуулах, нөөц ашигласны төлбөр төлөхгүй байгаа гэрээний тухайд төрийн захиргааны байгууллага гэрээлэгчтэй харилцан тохиролцож төлбөрийн хэмжээг тогтоохоор тусгасан явдал юм.

11 1991 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр БНМАУ-ын Бага хурлаас баталсан.

12 Газрын тосны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4. "уламжлалт бус газрын тос" гэж байгалийн битум, шатдаг занар, тослог элс, хийтэй элс, хийтэй занар, нүүрсний давхаргын метан хийг ойлгоно.

Газрын тосны тухай хууль ийнхүү шинэчлэн батлагдсанаар газрын тос болон уламжлалт бус газрын тосны эрх зүйн орчин тодорхой болж, газрын тосны салбарт төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын эрх, үүрэг, нөөц ашигласны болон тусгай зөвшөөрлийн төлбөрийн хувь хэмжээ, түүнийг ногдуулах, хөнгөлөх, чөлөөлөх нөхцөл журам, тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, газрын тос эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаанд хяналт тавихтай холбоотой зохицуулалт боловсронгуй болжээ.¹³

Уг хууль батлагдсанаас хойш 2015 онд 3 удаа, 2017 онд 1 удаа, 2020 онд 1 удаа, 2021 онд 2 удаа, 2022 онд 1 удаа буюу нийт 8 удаагийн өөрчлөлтөөр 33 зүйл заалтад нэмэлт, өөрчлөлт оруулсны 23 нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбоотойгоор аймаг, сум, багийн Засаг дарга болон иргэдийн Төлөөлөгчдийн хурлын бүрэн эрхтэй холбоотой заалтууд байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу "...хуульд өөрөөр заагаагүй бол ... хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх" зохицуулалттай бөгөөд үүний дагуу Газрын тосны тухай хуулийн хэрэгжилт, үр дагаврын үнэлгээ 2019 хийгдэх ёстой байв. Хуулийн хэрэгжилтэд гарч байгаа хүндрэл бэрхшээл, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлж, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох ажил ийнхүү 2023 оны жилийн эцсийн байдлаар хийгдээгүй хэвээр байна.¹⁴

Түүнчлэн газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагаа болон тухайн харилцаанд оролцогчдын эрх, үүргийг зохицуулах нарийвчилсан журам батлан гаргах үүргийг холбогдох байгууллагуудад хуулиар оногдуулсан байдаг. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. Газрын тосны тухай хуульд заасан журам, батлан гаргах үүрэг бүхий байгууллага

Д/д	Эрх зүйн актын нэр	Журам баталсан шийдвэр
1	Гэрээлэгчийг сонгон шалгаруулах журам	Уул уурхайн сайдын 2014 оны 202 тоот тушаал
2	Бүтээгдэхүүн хуваах гэрээний загвар	Засгийн газрын 2015 оны 104 дүгээр тогтоол
3	Газрын тос, уламжлалт бус газрын тосны чиглэлээр мэргэжлийн зэрэг олгох журам	Уул уурхайн сайдын 2015 оны 53 тоот тушаал

¹³ Газрын тосны тухай хуулийн танилцуулга, www.parliament.mn

¹⁴ Эх сурвалж: АМГТГазар

4	Уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалттай холбогдсон харилцааг зохицуулах тухай журам	Засгийн газрын 2015 оны 295 тоот тогтоол
5	Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайланд тавих шаардлага	Уул уурхайн сайдын 2015 оны 49 тоот тушаал
6	Гэрээлэгчийг сонгон шалгаруулах тухай журам	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны 202 тоот тушаал
7	Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах журам	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/06 тушаал
8	Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авах журам	БОАЖЯ, УУХҮЯ-ны 2018 оны А/50, А/31 тушаал
9	Газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тавих шаардлага	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А/07 тушаал
10	Нөөц ашигласны төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах журам	Засгийн газрын 2018 оны 5 дугаар тогтоол
11	Газрын тосны бүртгэл, тооцооны журам	Засгийн газрын 2019 оны 178 дугаар тогтоол
12	Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын ажлын жилийн төлөвлөгөө, төсөв зохиох заавар	АМГТГ-ын даргын 2021 оны А/09 тушаал
13	Газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны А/287 дугаар тушаал
14	Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны А/288 дугаар тушаал
15	Газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын ажлын тайлан боловсруулах журам	Батлагдаагүй.

Дээрх хүснэгтэд дурдсан журмуудыг хууль хэрэгжиж эхэлснээс хойш 1-8 жилийн дараа батлан гаргасан төдийгүй зарим журам өнөөг хүртэл батлагдаагүй байгаа нь харагдаж байна.

Бүтээгдэхүүн хуваах гэрээ нь газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагаа эрхлэх талаар төрийн захиргааны байгууллага, гэрээлэгчдийн хооронд байгуулах эрх зүйн баримт бичиг¹⁵ бөгөөд гэрээний талууд нь Засгийн газар болон Гэрээлэгч байна.

15 Газрын тосны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.14. "бүтээгдэхүүн хуваах гэрээ" гэж энэ хуулийн хүрээнд газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, гэрээлэгчийн хооронд байгуулсан гэрээг ойлгоно.

БХГ-нд Засгийн газар нь хайгуул, ашиглалтын талбайн гэрээлэгчийг сонгож, тусгай зөвшөөрөл олгох, гэрээ байгуулах, гэрээний хугацаанд хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд бүх талын хяналт тавих, олборлосон бүтээгдэхүүнийг өөрийн мэдэлд байлгах, өртөг нөхөгдсөний дараа үлдсэн бүтээгдэхүүн буюу ашигт тосыг¹⁶ хувааж авах эрх, үүрэгтэйгээр оролцдог бол Гэрээлэгч нь газрын тосны нөөц ашигласны төлбөрийг Засгийн газарт төлөх, хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны зардлаа (өртөг нөхөлт) гэрээнд заасан хувь хэмжээгээр дагуу тооцож авах, харин ашигт газрын тосыг Засгийн газартай мөн гэрээнд заасан хувь хэмжээгээр хуваан авах эрх, үүрэгтэй оролцдог. БХГ-ний хугацаа дуусахад суурилуулсан тоног төхөөрөмж Засгийн газрын мэдэлд үлддэг.

Манай улс 2024 оны байдлаар хайгуулын нийт 33 талбай ялгаснаас 28 талбайд 31 гэрээлэгч БХГ байгуулсан ба хөрөнгө оруулагчид нь харьяаллын хувьд Монгол Улсаас гадна БНХАУ, Канад, Швейцар, Их Британийн Каймэний арлын улс, Австрали зэрэг улс байна.¹⁷

Газрын тосны тухай хуульд БХГ-ний загварыг ЗГ батлахаар заасны дагуу 2015 онд Засгийн газрын “Бүтээгдэхүүн хуваах гэрээний загвар батлах тухай” 104 дүгээр тогтоол,¹⁸ 2016 онд “Бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчлэх тухай” 130 дугаар тогтоол тус тус батлагдсанаар Газрын тосны тухай хууль 2014 оны 7 дугаар сарын 01-ний өдөр батлагдахаас **өмнө байгуулсан БХГ-үүдийн үндсэн нөхцөлийг нь өөрчлөхгүйгээр Засгийн газрын 2015 оны 104 дүгээр тогтоолд нийцүүлэн шинэчлэх арга хэмжээ авахыг эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагад даалгасан байна.** Уг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2016 оны А/57, 2018 оны А/12 тоот тушаалаар байгуулагдаж, Гэрээлэгч нартай хэлэлцээр хийснээр хайгуулын шатанд хэрэгжиж буй гэрээнүүдийг шинэчилсэн байна. Харин олборлолтын үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгчдийн зүгээс **“... зарцуулсан зардлын өртгийг нөхөж авч дуусаагүй, БХГ-г өөрчлөхгүй”** гэдэг байр суурьтай байгаагаас газрын тосны ашиглалтын дараах гэрээнүүдийг шинэчилж чадаагүй байна.

- БХГ-97 гэрээт талбайд 1997 онд байгуулсан;

¹⁶ Газрын тосны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.33. “ашигт газрын тос” гэж хүргэлтийн цэг дээр хэмжсэн нийт газрын тосноос энэ хуулийн 4.1.26, 4.1.32-т заасан газрын тосыг хасаад Засгийн газар болон гэрээлэгчийн хооронд хуваах газрын тосыг ойлгоно.”

¹⁷ Дэлгэрэнгүйг Хавсралт 1-с үзнэ үү.

¹⁸ <https://www.legalinfo.mn/law/details/11015?lawid=11015>

- Тосон-Уул (XIX) талбайд 1993 онд байгуулсан;
- Тамсаг (XXI) талбайд 1995 онд байгуулсан;
- Матад (XX) талбай 2006 онд байгуулсан БХГ-ний дагуу үйл ажиллагаа явагдаж байна.¹⁹

Ийнхүү 2014 оноос өмнө байгуулагдсан газрын тосны ашиглалтын талбайн гэрээнүүдийг Газрын тосны тухай хуульд нийцүүлэн шинэчлэхгүй байх нь газрын тосны олборлолт, борлуулалтын хэмжээ, экспортын орлого, татвар болон бусад хууль тогтоомж, инфляц болон валютын ханшийн өөрчлөлттэй уялдуулан гэрээлэгчээс төлөх төлбөр, хураамж, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого, урамшууллын хэмжээ, түүнчлэн ЗГ-тай хуваах ашигт газрын тос, нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ шинэчлэгдэхгүй буюу товчхондоо манай талд ашиггүй юм.

1.2. Газрын тосны салбар дахь санхүүгийн хяналт шалгалтын үе шат

Газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа гэрээлэгч нь жил бүрийн төлөвлөгөө, төсвийг АМГТГ-аар батлуулах²⁰ бөгөөд тухайн жилд оруулсан хөрөнгө оруулалт, гаргасан зардал, нөөц ашигласны төлбөр, олборлосон болон борлуулсан газрын тосны хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, хууль тогтоомжид заасан төлбөр, урамшуулал, үйлчилгээний хөлсний хэмжээ, санхүүгийн тайлан, өртөг нөхөгдөх зардлын тайлан, газрын тос хуваах тооцоог үнэн зөв гаргаж АМГТГ-т тайлан хүргүүлэх²¹, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэх үүрэгтэй.

Дээрх тайлагналаас **өртөг нөхөгдөх зардлыг** дэлгэрүүлж тайлбарлавал, Гэрээлэгчийн хайгуул, бүтээн байгуулалт, олборлолтын үйл ажиллагаа, татан буулгалтын үед буюу тухайн тайлант хугацаанд өөрөөс нь гарч байгаа зардлыг тооцон жилийн эцэст өртөг нөхөгдөх зардлыг тайлагнаж, эдгээр зардлыг олборлосон газрын тосноос БХГ-нд заасан хувь хэмжээгээр тос хэлбэрээр буцаан авах үйл явц юм. Үүнд дараах арван долоон төрлийн тавин тав орчим зардал хамаарна.

1. Хөдөлмөр эрхлэлтийн зардал;

¹⁹ АМГТГ-аас 2020 оны 08 дугаар сарын 10-ны байдлаар авсан мэдээлэл.

²⁰ Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.3. “жилийн төлөвлөгөө, төсвийг төрийн захиргааны байгууллагаар батлуулж, хэрэгжүүлэх”.

²¹ Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.14. “санхүүгийн тайлан, өртөг нөхөгдөх зардлын тайлан, газрын тос хуваах тооцоог энэ хуулийн 7.1.4-т заасан журмын дагуу үнэн зөв гаргаж, төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгөх”.

2. Тоног төхөөрөмж, техник хэрэгслийн зардал;
3. Бараа материалын зардал (нэр төрөл заана);
4. Гэрээлэгч, эсхүл гуравдагч этгээдийн үйлчилгээний зардал;
5. Хайгуул, ашиглалт, татан буулгалтын үйл ажиллагаанд шаардлагатай үйлчилгээ худалдан авах зардал;
6. Дэд бүтэц, харилцаа холбооны үйлчилгээний зардал;
7. Гэрээт талбайд барилга, байгууламж барих, ашиглах, арчлахтай холбоотой зардал;
8. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой зардал;
9. Эд хөрөнгийн даатгал;
10. Хууль ёсны эрх ашгаа хамгаалуулахаар гаргасан хууль зүйн үйлчилгээний зардал;
11. Захиргааны ажилчдаас бусад ажилтны ажил мэргэжлийн чиглэлээрх богино болон дадлагажуулах сургалтын зардал;
12. Хайгуул, ашиглалт, татан буулгалтын үеийн аюулгүй ажиллагаатай холбоотой зардал;
13. Газрын тосны үйл ажиллагаанд хэрэглэсэн усыг цэвэршүүлэх зардал;
14. Хайгуул ашиглалт, татан буулгалтын үйл ажиллагаанд ашиглах программ хангамж, техник хэрэгслийн зардал;
15. Хайгуул, ашиглалт, татан буулгалтын үйл ажиллагаанд гүйцэтгэх ажлын зураг төсөл, төлөвлөлтийн зардал;
16. Тухайн жилийн өртөг нөхөгдөх зардлын дүнгээс БХГ-нд заасан хувь хэмжээгээр тооцсон захиргааны зардал;
17. Гэрээт талбайд тухайн хуанлийн жилд 183 хоногоос доошгүй хугацаанд ажилласан удирдах болон бусад ажилтнуудын газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаатай холбоотой зардал.


Газрын тосны салбарын хяналт шалгалтын зорилго нь гэрээлэгчийн өртөг нөхөгдөх зардлын бүртгэлийн үнэн зөв байдлыг тогтооход оршино. Үүнд:

1. Өртөг нөхөх зардлыг хүлээн зөвшөөрөх журмыг баримталсан эсэх;
2. Өртөг нөхөгдөх зардалд үл тооцох зардал оруулсан эсэх;
3. Үндсэн хөрөнгө, бараа материал, ажил үйлчилгээ худалдан авах журмыг баримталсан эсэх;
4. Газрын тосны хэмжилтийн цэг, хэмжилтийг үнэн зөв тогтоосон эсэх;

5. Борлуулсан газрын тосны үнэ тогтоолт;
6. Нөөц ашигласны төлбөр, хуулийн дагуу төлөх төлбөр, урамшуулал, үйлчилгээний хөлсний хяналт;
7. Өртөгт болон ашигт газрын тосны тооцооллын тайланг анхан шатны баримт материалд үндэслэн хянан үзэж, дүгнэлт гаргах, тулган баталгаажуулах зэрэг багтана.

Схем-1

Газрын тосны санхүүгийн хяналт шалгалтын үе шат
(Газрын тосны бүртгэл, тооцооны журмаар)




Судалгааны дараагийн бүлэгт газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа гэрээлэгчдийн өртөг нөхөх зардлыг баталгаажуулах чиглэлээр хийгдсэн хяналт шалгалтуудын цагалбарт хугацаа, үр нөлөөний талаар авч үзэв.

БҮЛЭГ 2. ГАЗРЫН ТОСНЫ САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮР НӨЛӨӨ

2.1 Газрын тосны хайгуулын үе шатны санхүүгийн хяналт шалгалт, баталгаажуулалт

Тодорхой нутаг дэвсгэрт газрын тосны хэтийн төлөвийг тогтоох зорилгоор хийх геологи, геохими, геофизикийн тойм судалгааны ажлыг газрын тосны эрлийн, газрын тосны ордыг нээж, нөөцийн хэмжээг тогтоох зорилгоор гүйцэтгэх геологи, геохими, геофизик, өрөмдлөг, олборлолтын туршилтын ажлыг хайгуулын үйл ажиллагаа гэх бөгөөд 2023 оны байдлаар АМГТГ-аас 23 талбайд газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулах БХГ-г 20 гэрээлэгчтэй байгуулж, 10 талбай нээлттэй буюу БХГ байгуулаагүй байна.

Зураг 1. Газрын тосны хайгуулын талбай



Хүснэгт 3. Газрын тосны хайгуулын чиглэлээр 2015-2023 онд хийгдсэн санхүүгийн хяналт шалгалт, аудитын мэдээлэл

д/д	Газрын тосны хайгуулын чиглэлээр хийгдсэн хяналт шалгалт, аудитын нэр	Тайлант он	Хамрах хүрээ	Аудит хийгдсэн он
1	Газрын тосны тухай хуулийн хэрэгжилт, төлбөр тооцооны байдалд хийсэн аудит	2014	Газрын тосны тухай хуулийн хэрэгжилт, газрын тосны тухай хуулийн төлбөр тооцооны байдал	2015

2	Газрын тосны 2015, 2016 оны хайгуулын ажлын өртөг нөхөгдөх зардлыг баталгаажуулах аудит	2015-2016	БХГ-ний дагуу газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулсан 5 Гэрээлэгчийн үйл ажиллагааг хамруулсан.	2018
3	Газрын тосны салбарт БХГ-ээр 2017-2018 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан Гэрээлэгчийн хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлыг хянаж, баталгаажуулах	2017-2018	БХГ-ний дагуу газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулсан 8 Гэрээлэгчийн 9 талбайг хамруулсан.	2019
4	Газрын тосны салбарт БХГ-гээр 2019-2020 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан Гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардлыг баталгаажуулах аудит	2019-2020	БХГ-ний дагуу газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулсан 6 Гэрээлэгчийн 7 талбайг хамруулсан.	2023
5	Газрын тосны салбарт БХГ-гээр 2020-2021 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан Гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардлыг баталгаажуулах аудит	2020-2021	БХГ-ний дагуу газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн 11 талбайг хамруулсан.	2023

Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан огнооноос тооцвол газрын тосны хайгуулын үе шатны санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөлт хуанлийн 1-3 жилээр, баталгаажуулалт 1 жилээр хоцрогдолтой буюу 2022 оны санхүүгийн хяналт шалгалт, түүний тулган баталгаажуулалтын аудит 2023 оны жилийн эцсийн байдлаар хийгдээгүй байна.²²

Хугацааны хоцрогдол үүссэн шалтгаан:

- Гэрээлэгч Газрын тосны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1-т зааснаар санхүүгийн мэдээ тайланг дараа оны 1 дүгээр улиралд багтаан хүргүүлэхээр зохицуулсан боловч АМГТГ нь Гэрээлэгчийн тайланд хяналт шалгалт хийж дүгнэлт гаргах, дүгнэлтийг төрийн аудитын байгууллагад хүргүүлэх хугацааг Газрын тосны тухай хууль болон Засгийн газрын 2019 оны 178 дугаар тогтоолоор батлагдсан “Газрын тосны бүртгэл, тооцооны журам”-аар нарийвчлан зохицуулаагүй байна.
- ҮАГ нь дараа оны аудитын төлөвлөлт, аудитын сэдвийг Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т зааснаар УИХ-ын Төсвийн байнгын хороогоор батлуулах зохицуулалт нь мөн хугацааны нарийвчлал байхгүй. Үүнээс хамаарч дараа оны аудитын төлөвлөлтийг тухайн оны 2 эсвэл 4

22 Энэ талаар ҮАГ-аас 2024.01 сард тодруулга авахад 2024 онд гүйцэтгэхээр УИХ-ын 2023 оны 08 дугаар тогтоолоор батлуулсан байна. <https://audit.mn/wp-content/uploads/2023/11>

дүгээр улиралд батлуулдаг тул аудитын сэдвийн төлөвлөлтийн хугацаа хоорондоо уялдахгүй байна.

- Түүнчлэн АМГТГ болон ҮАГ-ын хүний нөөц, санхүүгийн чадавх болон бусад хүчин зүйлээс шалтгаалан санхүүгийн хяналт шалгалтын гүйцэтгэл удаашрах, эсхүл дараа оны хяналт шалгалт, болон аудитын гүйцэтгэлийг шүүхийн шийдвэрээр түдгэлзүүлэх зэрэг нь ийнхүү хугацааны хоцрогдол үүсэхэд нөлөөлж байна.

Ийнхүү хяналт шалгалтын хугацаа хоцрох нь Гэрээлэгчээс Засгийн газарт төлөх ашигт газрын тосны үнийн өнөөдрийн үнэ цэнийг бууруулж, улсын төсвийн орлого бүрдүүлэлт буурах дам нөлөөтэй. Харин ашигт газрын тосны гүйлгээг ам.доллараар гүйцэтгэхэд манай орны хувьд сүүлийн жилүүдэд ханшийн өсөлттэй холбоотой шууд эрсдэл гараагүй ч цаашид хугацааны хоцрогдол үргэлжлэх нь БХГ-ний хугацаанд болон хугацаа дууссанаас хойш өр төлбөр хуримтлагдах, төлөгдөхгүй байх, шүүхийн болон арбитрын маргаан үүсэх эрсдэлд хүргэж болзошгүй.

2015–2023 онд хийгдсэн газрын тосны хайгуулын үе шатны санхүүгийн хяналт шалгалт, баталгаажуулалт

Тус онуудад таван удаагийн аудитын тайлангаар хайгуулын үе шатны өртөг нөхөгдөх болон нөхсөн зардалд санхүүгийн хяналт шалгалт хийгдсэнээс 2014-2018 оны тайлант хугацааны санхүүгийн хяналт шалгалтыг нэг үе шаттайгаар (саарал өнгөөр ялгав) төрийн аудитын байгууллага гүйцэтгэсэн бол 2019-2021 оны хяналт шалгалтыг хоёр үе шаттайгаар (ногоон өнгөөр ялгав) АМГТГ-аас ирүүлсэн дүгнэлт, саналд үндэслэн төрийн аудитын байгууллага тулган баталгаажуулалт хийсэн байна. Үүнд:

2015 онд хийгдсэн “Газрын тосны тухай хуулийн хэрэгжилт, төлбөр тооцооны байдал”-д хийсэн аудитын тайлангаар:²³

- БХГ-ний зарим заалтыг Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлж, өөрчлөх, Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу боловсруулж мөрдөх дүрэм, журмуудыг яаралтай батлах зөвлөмжийг Уул уурхайн сайдад, Газрын тосны газар нь БХГ-нд заасан төлөөлөгчийг дэмжих сангийн 126.5 сая, сургалтын урамшууллын сангаас 391.5 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг илрүүлсэн байна.
- Түүнчлэн өртөг нөхөгдөх зардлыг баталгаажуулах журам, аргачлал байхгүйгээс Гэрээлэгч компаниудын өртөг нөхөгдөх зардлыг бодитой тооцоход бэрхшээлтэй, БХГ-ний дагуу өртөг нөхөгдөх зардалд хийсэн хяналт үр дүнгүй, гэрээлэгч талын гаргасан тооцооллоор бүтээгдэхүүн хувааж байгааг тогтоож, холбогдох дүрэм журмыг яаралтай гаргаж, мөрдүүлэхийг холбогдох албан тушаалтанд зөвлөсөн байна.

23 www.audit.mn

- Гэрээлэгчид БХГ-ний дагуу төлөх төлбөрөө бүрэн төлөөгүй буюу 2014 онд нийт борлуулсан тосноос МУЗГ-т 166.0 сая ам.долларын орлого төвлөрөхөөс 156.8 сая ам.доллар төвлөрч, 9.2 сая ам.доллар дутуу төвлөрсөн шалтгааныг тогтоож, нөхөн төлүүлсэн байна.

2018 онд хийгдсэн “Газрын тосны 2015, 2016 оны хайгуулын ажлын өртөг нөхөгдөх зардлыг баталгаажуулах” аудитын тайлангаар:²⁴

- Гэрээлэгч хайгуулын ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг бодитой төлөвлөхгүй, хөрөнгө оруулалтын гүйлгээг санхүүгийн тайланд нээлттэй тусгаагүй байгааг аудитаар тогтоож, 2015, 2016 онд нийт 13,918,703 ам.долларын зардлыг өртөг нөхөгдөх зардалд тооцохоор баталгаажуулсан байна. Эдгээр зардлууд нь Газрын тосны тухай хуулийн 11.2.6 “ хөрөнгө оруулалт, борлуулалтын орлоготой холбоотой гүйлгээг МУ-д бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх бөгөөд уг гүйлгээг санхүүгийн тайланд ил тод, нээлттэй тусгах”, мөн хуулийн 36.2 “Гэрээлэгч нь тусгай зөвшөөрөлтэй талбайд хийгдэж байгаа газрын тостой холбогдсон бүх үйл ажиллагааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаж, тайлагнана” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн 3 гэрээлэгчид хамааралтай байна.
- Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гэрээлэгчийн ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг батлах, түүний гүйцэтгэлд хяналт тавих хуулиар хүлээсэн чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байгааг тогтоосон байна.
- Үүнд: Газрын тосны тухай хуульд 11.2.3 “гэрээлэгч жилийн төлөвлөгөө, төсвийг төрийн захиргааны байгууллагаар батлуулж, хэрэгжүүлэх”-ээр заасан байхад 2015 онд 9 гэрээт талбай буюу 45%, 2016 онд 11 гэрээт талбай буюу 55% нь хөтөлбөр төсвөө Газрын тосны газарт хянуулаагүй, мөн 2015 онд 14 талбай буюу 70%, 2016 онд 17 талбай буюу 85% -д нь хайгуулын ажил хийгээгүй байгаа нь тус газар гэрээлэгчийн ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг батлах, тухайн жилийн хөрөнгө оруулалт, өртөг нөхөх зардлын тайланг хянаж, нэгтгэх чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байгаатай холбоотойг аудитаар илрүүлж, хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд болон АМГТГ-ын даргад зөвлөжээ.

2019 онд хийж, 2020 онд баталгаажуулсан “Газрын тосны салбарт БХГ-ээр 2017-2018 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлыг хянаж, баталгаажуулах аудит”-ын тайлангаар:²⁵

- Гэрээлэгчдийн санхүүгийн анхан шатны баримтгүй болон өртөг нөхөгдөхгүй зарим зардлыг өртөг нөхөгдөх зардлын тайланд тусгаж, бүртгэсэн 1,841,175.9 ам.долларыг аудитаар хасаж, тооцсон байна.

24 Мөн тэнд

25 Мөн тэнд

- Гэрээлэгчид БХГ-ээр хүлээсэн зарим чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал, хайгуулын талбайн өртөг нөхөгдөх зардалд тайлагнасан гүйлгээг гадаадын банкаар дамжуулан гүйцэтгэсэн, хайгуулын ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг батлуулсан боловч үйл ажиллагаа явуулаагүй, БХГ-ний дагуу өртөг нөхөх зардлын тайлан гаргаагүй зэрэг зөрчлүүд аудитаар илэрснийг холбогдох арга хэмжээ авсан.
- АМГТГ нь гэрээлэгчийн өртөг нөхөх зардлын тайланг улирал бүр хянаж, хүлээж авах чиг үүрэгтэй ч хуульд заасан чиг үүргээ бүрэн биелүүлээгүйгээс гэрээлэгчдийн өртөг нөхөх зардлын тайланд зөрүү үүссэн, БХГ-ний дагуу хайгуулын үйл ажиллагааны гүйцэтгэл хангалтгүй байгааг илрүүлж газрын тосны хайгуулын төлөвлөгөө, төсөв батлуулаагүй, үйл ажиллагаа явуулаагүй гэрээлэгчдийн асуудлыг нэгдсэн журмаар шийдвэрлэхийг Монгол Улсын ЗГ-т, гэрээлэгчийн хайгуулын ажлын төсөв, гүйцэтгэлд хяналт тавих, БХГ-ний хэрэгжилтийг хангуулах талаарх зөвлөмжийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад Газрын тосны тухай хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж ажиллахыг АМГТГ-т тус тус зөвлөсөн байна.

2022 онд хийж, 2023 онд баталгаажуулсан “Газрын тосны салбарт БХГ-ээр 2019–2020 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлыг хянаж, баталгаажуулах аудит”-ын тайлангаар:²⁶

- АМГТГ-аас Ажлын хэсэг гаргаж, 2019-2020 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчдийн өртөг нөхөх зардлаас нийт дүнгээр 2,733,471.0 ам. долларын хасагдах зардал тооцсон дүгнэлтэд анхан шатны баримт, нотлох зүйлсэд үндэслэн 2,937,802.0 ам.долларыг өртөг нөхөх зардлаас хасаж баталгаажуулсан буюу Гэрээлэгчид өртөг нөхөгдөх зардлыг үнэн зөв бүртгэж, тайлагнаагүй.
- АМГТГ нь гэрээлэгчдийн жилийн төлөвлөгөө, төсвийг батлахдаа бодит байдлыг харгалзаагүй, хайгуулын үйл ажиллагаанд хяналт шалгалтыг гэрээ, хууль тогтоомжид заасны дагуу бүрэн хэрэгжүүлээгүй байна.
- Газрын тосны тухай хуулийн 37.1-д заасны дагуу АМГТГ-ын гүйцэтгэх хяналт шалгалт санхүүгийн 1-2 жилийн хоцрогдолтой, тайлан нь алдаа зөрчилтэй, дүгнэлт гаргаж буй Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд голчлон төрөлжсөн мэргэжлийн инженерүүд байгаа нь санхүүгийн хяналт шалгалтын тайлан үнэн зөв, үндэслэл бүхий байж чадахгүй байна гэж тус тус дүгнэсэн байна.
- Тус аудитаар:- МУ-ын Ерөнхий сайдад: АМГТГ-аас гэрээлэгчдийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, санхүүгийн хяналт шалгалтын тайланг хүлээн авч үнэлэх, УУХҮЯ болон төрийн аудитын байгууллагад хүргүүлэх хугацааг тус тус цагалбартай болгох, УУХҮ-ийн сайдад: АМГТГ-ын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах...гэрээлэгчдийн хөрөнгө оруулалт, өртөг нөхөх зардлыг үнэн зөв бүртгэж, тайлагнасан байдалд хяналт тавих, АМГТГ-ын даргад: гэрээлэгчдийн өртөг нөхөх зардлын тайлан болон хяналт шалгалтын тайлангийн жишиг загвар

²⁶ Мөн тэнд

бий болгож, тайланг хүлээн авах, хүргүүлэх зэрэг асуудлыг журамлах чиглэлээр, Гэрээлэгчид: аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг 2019-2020 оны санхүүгийн тайлан болон өртөг нөхөх зардлын тайландаа залруулж, баталгаажуулан, АМГТГ болон ҮАГ-т хүргүүлэхийг, газрын тосны тухай хууль, хайгуулын үйл ажиллагаанд хамаарах зардлын гүйлгээг дотоодын арилжааны банкаар дамжуулах гүйцэтгэх, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг Монгол хэлээр хөтлөх, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдлийг хангаж, үнэн зөв тайлагнахыг тус тус зөвлөмж, төлбөрийн акт болон албан шаардлагыг тус тус ногдуулсан байна.

2023 онд хийж, баталгаажуулсан “Газрын тосны салбарт БХГ-ээр 2020-2021 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлыг хянаж, баталгаажуулах аудит”-ын тайлангаар:²⁷

- АМГТГ-с 2020-2021 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчдийн өртөг нөхөх зардлаас нийт дүнгээр 1,429,408.94 ам. долларын хасагдах зардал тооцсон дүгнэлтэд анхан шатны баримт, нотлох зүйлсэд үндэслэн 1,415,154.17 ам.долларыг өртөг нөхөх зардлаас хасаж баталгаажуулсан буюу Гэрээлэгч хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардлыг санхүүгийн болон өртөг нөхөх зардлын тайландаа үнэн зөв бүртгэж, тайлагнаагүй.
- АМГТГ нь гэрээлэгчийн үйл ажиллагаанд хууль тогтоомж, БХГ-ний дагуу хяналт тавиагүй, өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг бүрэн биелүүлээгүй.
- Гэрээлэгчид газрын тосны үйл ажиллагаатай холбоотой төлбөр тооцоог гадаадын банкаар дамжуулан гүйцэтгэсэн нь санхүүгийн ил тод байдал алдагдах, өртөг нөхөгдөх зардлын дүнг үндэслэлгүй нэмэгдүүлэх сөрөг үр дагавар бий болгосон.
- Дийлэнх гэрээлэгчид хайгуулын үнэлгээний хөрөнгө, хайгуулын зардал гэх 2 аргын алийг нь сонгож байгаагаа Нягтлан бодох бүртгэлийн баримт бичигт тусгаж мөрдөөгүйгээс санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдсэн, АМГТГ нь холбогдох хяналт, шалгалтын дүгнэлт, тайланг 1-2 жилийн хугацаа хоцролттой ирүүлж байгаагаас аудитаар баталгаажуулах өртөг нөхөгдөх зардалтай холбоотой тоо, мэдээллийг гэрээлэгчийн санхүүгийн тайлантай уялдуулан залруулга хийлгэх боломжгүй болгосон.
- Хайгуулын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, тайланг АМГТГ нь батлагдсан маягуудын дагуу хүлээн авдаггүй, санхүүгийн тайлантай уялдуулж хянадаггүйгээс төрийн аудитын байгууллагад алдаатай буруу илэрхийлсэн дүгнэлт, тайлан ирүүлж, аудитын эрсдэлийг нэмэгдүүлсэн.

27 Мөн тэнд

- АМГТГ нь хууль тогтоомжид заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүйгээс гэрээлэгчид 2020-2021 онд төлөх төлбөр, урамшуулал, байгаль орчны баталгааны нийт 1,692,199.7 ам. долларын өр төлбөр хуримтлагдсан.
- Тус аудитаар: Засгийн газарт: холбогдох эрх зүйн актуудын уялдааг хангуулах арга хэмжээ авахыг, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад: Газрын тосны тухай хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг хангаж ажиллах, Гэрээлэгч тайлант онд төлөвлөгөө, төсөв батлуулж, тухайн оны ихэнх хугацаанд үйл ажиллагаа явуулж байгаад “түр зогсолт авах” хүсэлт гаргасан тохиолдолд уг хугацаанд зарцуулсан зардлыг өртөг нөхөгдөх зардал зардалд оруулах эсэх талаар БХГ-нд тодорхой тусгах, АМГТГ-ын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулахыг, АМГТГ-ын даргад: тухайн оны санхүүгийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэхдээ гэрээлэгчийн баталгаажуулсан цахим санхүүгийн тайлан, тодруулгыг үндэслэж шалгах, гэрээлэгчдээс тухайн оны санхүүгийн тайлан, тодруулга, өртөг нөхөх зардлын хураангуй болон дэлгэрэнгүй тайлан зэргийг үндэслэж байхыг Гэрээлэгчид: холбогдох тайланг бүрэн гүйцэд, үнэн зөв тайлагнахыг, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллахыг тус тус зөвлөсөн байна.

2.2 Газрын тосны олборлолтын үе шатны санхүүгийн хяналт шалгалт, баталгаажуулалт

Газрын тосны олборлолт, ашиглалтыг энгийнээр газрын тосны эрэл, хайгуул хийж, нөөц нь баталгаажсан орд газарт өрөмдлөг, олборлолтын үйл ажиллагаа явуулж, газрын гүнээстосыг олборлолтын яндан хоолойгоор гаргаж, олборлох, олборлолт буурсан үед дундаргыг нэмэгдүүлэх физик-хими²⁸, физик-дулааны²⁹, термо-химийн³⁰ аргуудыг ашиглах технологийн горим, үйл явц хэмээн тайлбарлаж болох юм.


2023 оны байдлаар газрын тосны ашиглалтын дөрвөн талбайд гурван гэрээлэгч БХГ-байгуулан олборлолтын үйл ажиллагаа явуулж байна.

²⁸ Ус, химийн уусмал шахах.

²⁹ Халуун ус, уур шахах.

³⁰ Цооногийн ёроолд гал гаргах.

Зураг 2. Газрын тосны ашиглалтын талбай



Хүснэгт 4. Газрын тосны олборлолтын чиглэлээр 2015-2023 онд хийгдсэн санхүүгийн хяналт шалгалт, аудитын мэдээлэл

д/д	Газрын тосны олборлолтын чиглэлээр хийгдсэн хяналт шалгалт, аудитын нэр	Тайлант он	Хамрах хүрээ	Аудит хийгдсэн он
1	Газрын тосны салбарт БХГ-ээр олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн "БХГ-97" талбайн 2014 оны хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон өртөг нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийсэн аудит	2014	БХГ-97 талбай	2020
2	Газрын тосны салбарт БХГ-ээр олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн "БХГ-97" талбайн 2015-2018 оны хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон өртөг нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийсэн аудит	2015-2018		2021
3	Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийсэн аудит	2014-2018	Тосон-Уул (ХИХ) талбай Тамсаг (ХХІ) талбай	2022
4	Газрын тосны салбарт БХГ-ээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудит	2019-2021	Тосон-Уул (ХИХ) талбай Тамсаг (ХХІ) талбай	2023

Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан 2014 оноос хойших газрын тосны олборлолтын үе шатны санхүүгийн хяналт шалгалтын байдал:

- Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн “БХГ-97” талбайн санхүүгийн хяналт нь 2019-2022 оны аудитыг гүйцэтгэх төлөвлөлтийг хугацааг 2014-2018 оныг хамарсан аудитын тайлангаар өгсөн албан шаардлагатай холбоотой маргааныг 3 шатны шүүхээр шийдвэрлүүлэх явцад түдгэлзүүлсэн,³¹ мөн АМГТГ-аас хяналт шалгалтын дүгнэлт, тайланг ирүүлээгүй зэргээс шалтгаалан **хуанлийн 4 жилээр хоцорсон;**
- “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн Тосон-Уул (ХІХ), Тамсаг (ХХІ) талбайн хувьд **хуанлийн 1 жилийн хоцрогдолтой** буюу 2022 оны санхүүгийн хяналт шалгалт, түүний баталгаажуулалтын аудит хийгдээгүй;
- Петро Матад ХХК-ийн (Матад ХХ) талбайн хяналт шалгалтын дүгнэлт, тайланг АМГТГ-аас ирүүлээгүй тул **хуанлийн 1 жилийн хоцрогдолтой** буюу 2022 оны санхүүгийн хяналт шалгалт, түүний баталгаажуулалтын аудит хийгдээгүй байдалтай байна.

ҮАГ-аас 2024 оны 1 сард тодруулга авахад АМГТГ-аас гэрээлэгчдийн санхүүгийн хяналт шалгалтын тайлан, дүгнэлтийг хуульд заасан шаардлага ханган ирүүлсэн нөхцөлд аудитыг 2024 онд гүйцэтгэхээр УИХ-ын 2023 оны 08 дугаар тогтоолд тусган батлуулсан байна.

Түүнчлэн Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн Тосон-Уул (ХІХ), Тамсаг (ХХІ) талбайн 2019-2021 оны үйл ажиллагаанд хийгдсэн аудитаар **“дүгнэлт гаргахаас татгалзсан” буюу баталгаажуулалт хийгдээгүй** тул тухайн онуудыг хамруулсан аудитыг дахин хийх эсэх нь тодорхойгүй, аудитын дүгнэлт болон зөвлөмжид зөрчлөө арилгаж, дахин аудитад хамрагдах эсэх талаар дурдаагүй байна.

Хугацааны хоцрогдол үүссэн шалтгаан нь Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн хувьд Ковид-19 цар тахлаас үүдэн хилийн хориг, хорио цээрийн дэглэм үргэлжилсэнтэй холбоотойгоор 2020.01.25-2021.05.08 хүртэл хугацаанд аудит зогсонги байдалд орсонтой холбоотой байна.

Харин Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн хувьд хяналт шалгалтын хоцрогдол үүссэн шалтгаан нь АМГТГ-аас тус компанийн 2014-2018 оны санхүүгийн хяналт шалгалтын дүгнэлт, саналыг 2021 онд, 2019-2021 оны санхүүгийн хяналт шалгалтын дүгнэлт, саналыг 2023 онд тус тус төрийн аудитын байгууллагад хүргүүлсэнтэй холбоотой байна.

31 Уг шүүхийн маргаан 2023.03 сард эцэслэн шийдвэрлэгдэж, ҮАГ-ын албан шаардлагыг хэвээр үлдээсэн байна. Эх сурвалж: ҮАГ-ын 2023 оны 01\1132 тоот албан бичиг

2015–2023 оны хооронд хийгдсэн газрын тосны олборлолтын үе шатны санхүүгийн хяналт, баталгаажуулалт:

Тус онуудад дөрвөн удаа олборлолтын үе шатны өртөг нөхөх зардал болон нөхсөн зардалд аудитын санхүүгийн хяналт шалгалт хийгдсэнээс Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн “БХГ-97” талбайн 2014 болон 2015-2018 оны тайлант хугацааны санхүүгийн хяналт шалгалтыг нэг үе шаттайгаар төрийн аудитын байгууллага гүйцэтгэсэн бол Петрочайна Дачин тамсаг ХХК-ийн хоёр талбайн санхүүгийн хяналт шалгалтыг хоёр үе шаттайгаар буюу АМГТГ-аас ирүүлсэн дүгнэлт, саналд үндэслэн аудитын байгууллага тулган баталгаажуулсан байна.

Олборлолтын үе шатанд хоёр гэрээлэгчийн гурван талбай санхүүгийн хяналт, шалгалтад хамрагдсан ба үүнийг аудитын баталгаажуулалт, үр дүнг гэрээлэгч тус бүрээр хураангуйлан харуулбал:

1.Доншен газрын тос (Монгол) ХХК:

2020 онд хийгдсэн аудитаар³²:

- Гэрээлэгч 2014 онд гүйцэтгэх хөтөлбөр, төсвийг бодитой төлөвлөөгүй, нэмэлт хөтөлбөр төсөв батлуулсан үндэслэл тодорхойгүй.
- Гэрээт түүхий тосыг худалдан борлуулах гэрээнд гэрээт талбайгаас олборлосон бүх түүхий тосыг худалдах, худалдан авах ерөнхий нөхцөл, үнийн тохиролцоог тусгасан бөгөөд МУЗГ-ын хувьд хяналт, оролцоогүй байна.
- Гэрээлэгч 2014 оны өртөг нөхөх зардлыг тайлагнахдаа “БХГ-97” гэрээний 25.2, хавсралт гэрээний “В”-ийн 2 дугаар зүйл, мөн тухайн үед дагаж мөрдөж байсан Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөнийг аудитаар тогтоож, нийт 4,239,997.98 ам.долларын зардлыг өртөг нөхөгдөх зардлаас хасаж тооцсон.
- Гэрээлэгчийн тайлагнасан хөрөнгө оруулалт, зардал, нөөц ашигласны төлбөр, олборлосон болон борлуулсан газрын тосны 2014 оны тайланг Газрын тосны газар /хуучин нэрээр/ хүлээн авсан боловч өртөг нөхөгдөх зардлын ангилал, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримттай тулгаж, хянаж, нэгтгэх, талуудын эрх бүхий этгээдийн гарын үсгээр баталгаажуулах ажил хийгдээгүй.

32 www.open.audit.mn

Тус аудитаар:

- **МУ-ын Ерөнхий сайдад:** Газрын тосны олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа гэрээлэгчийн БХ-ний зохицуулалтыг тодорхой болгох, хууль тогтоомжид нийцүүлэх ажлыг эрчимжүүлэх, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг УУХҮЯ-д даалгах,
- **Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад:** Гэрээлэгчийн жилийн ажлын хөтөлбөр, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийг хянах, нэгтгэх, тайлагнахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, “БХГ-97” гэрээнд заасан олборлолтын үйл ажиллагаа эхэлснээс хойш хоёр үе шаттайгаар 10 жилийн хугацаанд татвараас чөлөөлөхөөр заасан хугацааг нарийвчлан тогтоож, хэрэгжилтэд хяналт тавих, МУ-д ногдох гэрээт түүхий тосны худалдан борлуулах, экспортлох үнийг тогтооход ЗГ-ын хяналт, оролцоог бий болгох,
- **АМГТГ-ын даргад:** Өртөг нөхөх зардлын тооцоололд гарсан “БХГ-97”-нд заасан экспортын цэгийн ойлголтын зөрүүг арилгаж, цаашид тооцооллын зөрүү гаргахгүй байх, гэрээлэгчийн өртөг нөхөгдөх зардлын тайланг хянаж, нэгтгэл хийх ажлыг хэвшүүлж, хяналт тавихыг тус тус зөвлөсөн байна.

2021 онд хийгдсэн аудитын тайлангаар ³³

- Гэрээлэгч нь ӨНЗ-ын **2015–2018** оны тайланд нийт 6,052.8 мянган ам.долларын ӨНЗ-д орохгүй зардлыг илүү бүртгэж, тайлагнасан байна.
- Аудитаар гэрээлэгчийн 2015-2018 онд тайлагнасан нийт зардлаас Зүүнбаян танкфармын боловсруулалтын төвийн өртөг болох 7,099.6 мянган ам.долларыг борлуулалтын зардал биш гэж үзэн өртөг нөхөгдөх зардалд шилжүүлж тооцсоноос 88.6 мянган ам.долларын зардал анхан шатны баримтаар нотлогдоогүй тул хасаж, 7,011.0 мянган ам.долларыг ӨНЗ-д залруулан тооцож баталгаажуулсан.
- АМГТГ нь гэрээлэгчийн газрын тостой холбоотой үйл ажиллагааны тайлан мэдээг хүлээн авах, тайланг хянах чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн, гэрээлэгчийн төсвийг батлахдаа байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх зардлын төлөвлөлтийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хянаагүй байна.
- “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн санхүүгийн анхан шатны баримт, материалыг хятад, өртөг нөхөгдөх зардлын тайланг англи хэл дээр тус тус үйлдэж байгаа нь Монгол хэлний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

33 www.open.audit.mn

- Бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчлэх талаарх Засгийн газрын 2016 оны 130 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, Газрын тосны тухай хууль тогтоомжтой нийцэхгүй байгаа зарим зүйл, заалтыг нийцүүлж Бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчлэн батлах шаардлагатай байна гэж дүгнэсэн байна.

Тус аудитаар:

- **МУ-ын Ерөнхий сайдад:** Газрын тосны тухай хууль болон Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангуулах, гэрээлэгчийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийн хүрээнд УУХҮЯ болон АМГТГ-т үүрэг, чиглэл өгч, үр дүнг тооцох,
- **Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад:** Газрын тосны тухай хуулиар эрх олгосон нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актыг тухай бүр боловсруулан батлуулах, хэрэгжилтийг хангуулах, газрын тосны хайгуулын болон олборлолтын үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгчийн санхүүгийн анхан шатны бүх баримт, материал болон өртөг нөхөгдөх зардлын тайланг монгол хэл дээр үйлдэж байх ажлыг зохион байгуулж, Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэх,
- **АМГТГ-ын даргад:** Гэрээлэгчийн тухайн онд гүйцэтгэсэн ажлын жилийн тайланг хүлээн авах, хянах чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх, МУЗГ-т ногдох роялти, өртөг нөхөлт, тос хуваалтын 2015-2018 оны зөрүү болох 1,923.0 мянган ам.долларыг улсын төсөвт төвлөрүүлж, гэрээлэгч компанитай тооцоо нийлэх.
- **Гэрээлэгчид:** Компанийн санхүүгийн анхан шатны бүх баримт, материал болон өртөг нөхөгдөх зардлын тайланг Монгол хэл дээр үйлдэх буюу Монгол Улсын Үндсэн хууль, болон бусад хууль тогтоомжийг мөрдөж ажиллах, “БХГ-97” гэрээг шинэчлэн байгуулах, үйл ажиллагаагаа Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлсэн байхад анхаарахыг тус тус зөвлөсөн байна.

2. Петрочайна Дачин тамсаг ХХК:

2022 онд хийгдсэн аудитын тайлангаар:³⁴

- Гэрээлэгчийн 2014-2018 онд нийт экспортолсон газрын тосны орлогоос борлуулалттай холбоотой гарсан 237.6 сая ам.доллар (12.3%)-ын зардлыг хасаж, үлдэх хэсгийн 24.3 хувь буюу 466.7 сая ам.доллар нь Монгол Улсын Засгийн газарт, 63.4 хувь буюу 1,219.5 сая ам.доллар нь гэрээлэгчид ногдож байна.

34 www.open.audit.mn

- Мөн Тосон Уул XIX талбайгаас 2014-2018 оны газрын тосны нийт борлуулалтын орлого 925.1 сая ам.доллараас 5 хувиар тооцон 46.2 сая ам.долларын роялти нөхөн тооцож баталгаажууллаа. Энэ нь Бүтээгдэхүүн хуваах гэрээг байгуулах үед хүчин төгөлдөр үйлчилж байсан БНМАУ-ын Газрын тосны тухай хуулийн 9 ба 10 дугаар зүйл, Тосон Уул XIX гэрээт талбайн Бүтээгдэхүүн хуваах гэрээний 2.2-т тусгасныг үндэслэн Тосон Уул XIX талбайн Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр тус талбайгаас олборлосон газрын тосонд 5 хувийн төлбөр /роялти/ тооцох хууль зүйн үндэслэлтэй байна.
- Талууд Бүтээгдэхүүн хуваах гэрээг Газрын тосны тухай хуульд нийцүүлэх талаар харилцан зөвшилцөлд хүрээгүйгээс гэрээг шинэчлэх ажил зогсонги байдалд хүрсэн, төслийн үр ашиг буурах эрсдэлтэй байна.
- БХГ-ний зарим зүйл, заалт татвар, нийгмийн даатгалын, Нягтлан бодох бүртгэлийн болон бусад хууль тогтоомжтой зөрчилдөж байгаагаас шалтгаалж төсөвт татвар, хураамжийг дутуу төвлөрүүлэх, тайлан мэдээг зөрүүтэй тайлагнах, төрийн байгууллагуудтай үл ойлголцол, маргаан гарах нөхцөл үүсэж байна.
- Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу олборлосон гэрээт түүхий тосыг дотоодын зах зээлд борлуулах, нийлүүлэх талаар тодорхой эрх зүйн орчин бүрдээгүй байгаа нь үндэсний газрын тосны үйлдвэрийн үйл ажиллагааг хэвийн явуулахад уялдахгүй байх өндөр эрсдэл бүхий байна.
- Газрын тос экспортлох үйл ажиллагааны үед гарах технологийн хорогдол тооцох аргачлал, хэмжээг гэрээлэгч талууд харилцан тохиролцож баталгаажуулаагүйгээс бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу гаргасан тайлан, тооцооллууд зөрүүтэй байна.
- Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хуваарилсан Монгол Улсын Засгийн газарт ногдох орлогыг хугацаанд нь бүрэн төвлөрүүлээгүй, үлдэгдлийг тухай бүр тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.
- АМГТГ-ын гэрээлэгчтэй холбоотой бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан тайлангууд болон газрын тосны ашиглалтын үеийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг хянаж, нэгтгэх, гэрээлэгчийн жилийн ажлыг нэгтгэж дүгнэх, төлөвлөгөө төсвийн гүйцэтгэлийг харьцуулах, дүн шинжилгээ хийх үндсэн чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй, бүтцийн нэгжүүдийн ажлын уялдаа муу.
- “Петрочайна Дачин Тамсаг” ХХК нь газрын тостой холбоотой үйл ажиллагааг санхүүгийн тайланд тусгаагүй, анхан шатны баримтыг болон газрын тосны борлуулалтын орлого, өртөг нөхөгдөх зардлын тайланг хятад, англи хэлээр үйлдэж байгаа нь Монгол хэлний тухай, Нягтлан

бодох бүртгэлийн тухай, Газрын тосны тухай хуулийн холбогдох заалттай тус тус нийцэхгүй байна.

- Гэрээний талууд БХГ-ний дагуух газрын тосны болон санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулах, нэгдсэн цахим систем бий болгоход анхаарах шаардлагатай байна.
- БХГ-ний дагуух үйл ажиллагаа, төсөвт төвлөрүүлэх орлого зэрэгт газрын тосны болон төсөв санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас хяналтыг бүрэн хэрэгжүүлэхгүй байна.
- БХГ-ний зарим заалтыг Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлж өөрчлөх, Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу боловсруулж мөрдөх дүрэм, журмуудыг яаралтай батлах зөвлөмжийг Уул уурхайн сайдад, Газрын тосны газар нь БХГ-нд заасан төлөөлөгчийг дэмжих сангийн 126.5 сая, сургалтын урамшууллын сангаас 391.5 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг илрүүлсэн байна.
- Гэрээлэгчид БХГ-ний дагуу төлөх төлбөрөө бүрэн төлөөгүй буюу 2014 онд нийт борлуулсан тосноос МУЗГ-т 166.0 сая ам.долларын орлого төвлөрөхөөс 156.8 сая ам.доллар төвлөрч, 9.2 сая ам.доллар дутуу төвлөрсөн шалтгааныг тогтоож, нөхөн төлүүлсэн байна.
- Түүнчлэн өртөг нөхөгдөх зардлыг баталгаажуулах журам, аргачлал байхгүйгээс Гэрээлэгч компаниудын өртөг нөхөгдөх зардлыг бодитой тооцоход бэрхшээлтэй, БХГ-ний дагуу өртөг нөхөгдөх зардалд хийсэн хяналт үр дүнгүй, гэрээлэгч талын гаргасан тооцооллоор бүтээгдэхүүн хувааж байгааг тогтоож, холбогдох дүрэм журмыг яаралтай гаргаж, мөрдүүлэхийг холбогдох албан тушаалтанд зөвлөсөн байна.

Тус аудитаар:

- **Монгол Улсын Ерөнхий сайдад:** Газрын тосны салбарт олборлолтын үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгчийн БХГ-г шинэчлэхийг УУХҮЯ, АМГТГ-т чиглэл өгч, хэрэгжилтийг хангуулах, БХГ-ний дагуу олборлосон гэрээт түүхий тосыг дотоодын зах зээлд борлуулах, нийлүүлэх талаар эрх зүйн орчныг бүрдүүлэх,
- **Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад:** Гэрээлэгчийн жилийн ажлын төлөвлөгөө, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийг хянах, нэгтгэх, тайлагнахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, Гэрээлэгчийн БХГ-ний дагуу явуулж буй үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагын /гааль, татвар, нийгмийн даатгал, нийгмийн халамж, мэргэжлийн хяналт, орон нутгийн удирдлага гэх мэт/ үйл ажиллагаа хоорондоо хэрхэн уялдаж байгаа талаар болон БХГ-ний

- хууль тогтоомжийн нийцлийн судалгаа хийж, арга хэмжээ авах, Газрын тосны ашиглалтын үеийн үйл ажиллагааны анхдагч мэдээлэл, тайлан, материалыг хүлээн авах, хянах ажлыг журамлах,
- **Ашигт малтмал, газрын тосны газрын даргад:** Гэрээлэгчийн жилийн болон нэмэлт төлөвлөгөө, төсвийн тооцоолол, түүний үндэслэл, өөрчлөлт оруулах шалтгааныг судалж баримтжуулах, батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу жилийн ажлыг нэгтгэж дүгнэх, өртөг нөхөх зардал болон олборлосон, борлуулсан газрын тосны тайланг улирлаар тасалбар болгон анхан шатны баримттай тулган хянаж, тооцоо нийлж, баталгаажуулан нэгтгэж байх, Гэрээлэгчийн тусгай зөвшөөрөлтэй талбайд хийж байгаа газрын тостой холбоотой үйл ажиллагааны баримт бичгийг монгол хэлээр хөтлөх, санхүүгийн тайланд ил тод, нээлттэй, бүрэн тусгаж тайлагнах арга хэмжээг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлэх, газрын тосны ашиглалтын үеийн үйл ажиллагааны анхдагч мэдээлэл, тайлан, материалыг хүлээн авах, хянах ажлыг, журамлах, эзэнжүүлэхийг тус тус зөвлөсөн байна.

2023 онд хийгдсэн аудитын тайлангаар³⁵

- “Петрочайна Дачин Тамсаг” ХХК нь газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд хамаарах ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд иж бүрэн, үнэн зөв тайлагнаагүй тул аудитаар үр дүнг баталгаажуулах боломжгүй байна.
- БХГ-г зөрчиж 7,228.7 тэрбум төгрөгийн өртөг зардлыг нөхөж авахаар хуримтлуулж тооцсон нь МУ-д ногдох газрын тосны орлогын хэмжээг бууруулах эрсдэлтэй байна.
- Тосон-Уул XIX талбайн БХГ-ний хэрэгжилтийг дүгнээгүй, хугацаа дууссан, эрх зүйн зохицуулалтгүй олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаагаас шалтгаалж Монгол Улсын эрх ашиг хөндөгдөж байна.
- АМГТГ нь гэрээлэгчээс ирүүлсэн газрын тосны үйл ажиллагаатай холбоотой тайлан мэдээг санхүүгийн тайлантай уялдуулж хянаж шалгаагүйгээс нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлого хуваарилалтын тооцоо буруу илэрхийлэгдсэн байна.
- АМГТГ нь Газрын тосны тухай хууль болон БХГ-нд заасан хяналт хэрэгжүүлэх чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүйгээс гэрээлэгч талд эрх зүйн зохицуулалтаар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх давуу байдал олгосон байна.

35 www.audit.mn

- УУХҮЯ нь газрын тосны салбарын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлснээс аудитаар өгсөн зөвлөмж хэрэгжихгүй, алдаа зөрчил давтагдаж байна гэж дүгнэсэн байна.

Тус аудитаар:

- **УИХ-д:** Газрын тосны олборлолтын үйл ажиллагаанаас МУ-д ногдох хувь хэмжээг нэмэгдүүлэх, олборлосон бүтээгдэхүүнийг захиран зарцуулах, хяналт тавих эрх зүйн зохицуулалтыг бий болгох,
- **Монгол Улсын Засгийн газарт:** БХГ-ний дагуу үр ашигтай нээлтийн цоногийг илрүүлсэн хугацааны бүртгэлийг үнэн зөв хийх, хяналт тавих, БХГ-нд заасны дагуу "...гэрээлэгч буюу ЗГ-ын хувьд шударга, эрх тэгш бус болох нь нотлогдвол талууд буцааж дээрх арга замын шударга, тэгш бус аливаа зүйлийг залруулахад шаардлагатай өөрчлөлтүүдийн талаар тохиролцохыг хичээнгүйлэн эрмэлзэнэ" гэх заалтыг хэрэгжүүлэх, Гэрээлэгч БХГ-нд заагдсан эрх үүргээ хэрэгжүүлэхгүй байх, зөрчлийг давтан гаргаж байгааг зогсоох арга хэмжээг авч, хариуцлага тооцох, газрын тосны олборлолт, борлуулалт, хөрөнгө оруулалт, өртөг зардлын нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх,
- **АМГТГ-т:** Гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтыг хянахдаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу харилцагч санхүүгийн байгууллагын баталгаажуулсан цахим санхүүгийн тайлан, тодруулгыг үндэслэж шалгаж байх, гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, газрын тосны экспорт, борлуулалтын орлого зөрүүтэй байвал хянан шалгаж, дүгнэлт тайланд бүрэн тусгаж ирүүлж байхыг тус тус зөвлөсөн байна.

Газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа гэрээлэгчдийн хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, гэрээлэгч болон Монгол Улсын Засгийн газрын хооронд хуваах ашигт тосны хэмжээг БХГ-ний дагуу үнэн зөв бүртгэж, тайлагнаж, түүний төлбөр улсын төсөвт цаг хугацаандаа төвлөрч чадаж байгаа эсэхэд хийгдсэн АМГТГ-ын дүгнэлт, түүнийг тулган баталгаажуулсан төрийн аудитын байгууллагын тайлангийн үр дүнгүүдийг хураангуйлан дүгнэвэл дараах хэд хэдэн асуудал анхаарал татаж байна. Үүнд:

1. **Гэрээлэгчид:** Хайгуул болон олборлолтын үйл ажиллагаа явуулахдаа БХГ болон Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлдэггүй зөрчил нийтлэг байна. Тухайлбал, бүртгэл тооцоо, тайлагналыг үнэн зөв хөтөлдөггүй, өртөг нөхөгдөх зардлыг илүү бүртгэдэг, тайлагналыг Монгол

хэлээр үйлддэггүй, борлуулалтын орлого, зарлагын гүйлгээг гадаадын арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэдэг, БХГ-ний дагуу хуваарилсан Монгол Улсын Засгийн газарт ногдох орлогыг хугацаанд нь бүрэн төвлөрүүлээгүй, авлага үүсгэсэн, олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа Гэрээлэгчид БХГ-г шинэчлэхийг зөвшөөрдөггүй, үр ашигтай нээлт хийсэн огноог баталгаажуулаагүй, олборлосон түүхий тосыг худалдах, худалдан авах ерөнхий нөхцөлийг Засгийн газартай харилцан тохиролцоогүй зэрэг зөрчлүүд байна. Төрийн аудитын байгууллагаас дээрх зөрчлүүдийг арилгах зөвлөмж, албан шаардлагыг жил бүр тавьж, илүү бүртгэсэн өртөг нөхөгдөх зардлыг аудитаар хасаж тооцож, буцаан төлүүлсэн боловч бусад зөвлөмжийн хэрэгжилт хангагдсан эсэх мэдээлэл дараа оны тайланд тухай бүр тусгагдаагүй, зөрчил давтагдсан байдалтай байна. Харин тухайн жилийн төлөвлөгөө, төсвийг батлуулаагүй, батлагдсан төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулаагүй зэрэг зөрчлүүд давтан гарсан эсэх талаар аудитын тайланд дурдагдах нь жил ирэх бүр багасаж байгаа нь төрийн аудитын байгууллагын хяналт, шалгалтын үр нөлөө гэж болохоор байна.

2. АМГТГ: Тус газрын Газрын тосны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлт хангалтгүй буюу хайгуулын болон олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа гэрээлэгчдийн жилийн төлөвлөгөө, төсвийг хянаж батлаагүй эсхүл санхүүгийн болон үйл ажиллагааны бодит төлөвлөлт хийсэн эсэхэд хяналт тавьдаггүйгээс зарим Гэрээлэгчдийн төсөв дэх байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх зардлын төлөвлөлт хянагдаагүй, гэрээлэгчийн газрын тосны хайгуул болон олборлолтын үйл ажиллагаанд хяналтыг зохих ёсоор тавиагүй, хайгуулын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, тайланг батлагдсан маягтуудын дагуу хүлээн авдаггүй, өртөг нөхөгдөх зардлын бүртгэл болон бусад санхүүгийн тайлан тооцоог хянадаггүй, БХГ-ний дагуу төлөх төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлэх хугацааг хоцроосон, сар бүр тооцоо нийлж, баталгаажуулаагүй өр төлбөр үүсгэсэн, Гэрээлэгчдэд хийх санхүүгийн хяналт шалгалтыг 1-5 жилийн хоцрогдолтой, тайлан дүгнэлт нь алдаатай, санхүүгийн тайлантай уялдуулж хянадаггүйгээс аудитын байгууллагад алдаатай буруу илэрхийлсэн дүгнэлт тайлан ирүүлж, аудитын эрсдэлийг нэмэгдүүлсэн, өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг бүрэн биелүүлээгүй зэрэг зөрчлүүд давтагдсаар байна. Мөн БХГ-г шинэчлэх, Монгол Улсын хууль тогтоомжтой нийцүүлэх ажлыг эрчимжүүлээгүй, Тосон-Уул XIX талбайн БХГ-ний хэрэгжилтийг дүгнээгүй, хугацаа дууссан, эрх зүйн зохицуулалтгүй олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаагаас шалтгаалж Монгол Улсын эрх ашиг хөндөгдөж байхад

удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ аваагүй, гэрээлэгч талд үүргээ биелүүлэхгүй байх давуу байдал олгосон, мөн хуулиар олгогдоогүй эрх эдэлж, гэрээлэгчтэй 2004 онд нэмэлт хэлэлцээрээр хайгуулын хугацааг 5 хүртэл жилээр сунгахаар тохиролцсон, түүхий тос тээвэрлэх, борлуулах протоколоор борлуулалтын зардлыг Засгийн газраас эргүүлэн авахаар тохирсон (Петрочайна Дачин Тамсаг ХХК), гэрээлэгчээс төлсөн зарим төрлийн төлбөрийг зориулалт бусаар зарцуулсан зэрэг ноцтой зөрчлүүд жил бүрийн аудитын тайланд дурдагдаж, тухай бүр дээрх зөрчлүүдийг арилгах зөвлөмж, албан шаардлага авч байжээ.

3. УУХҮЯ: Тус яамны Газрын тосны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлт хангалтгүй буюу Газрын тосны тухай хуулийг дагалдан гарах эрх зүйн актуудыг баталж, мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих үүргийн хэрэгжилт 1-8 жилийн хоцрогдолтой, БХГ-г шинэчлэх, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх ажлыг хариуцан хэрэгжүүлээгүй, үр ашигтай нээлтийн бүртгэлд хяналт тавиагүй болон БХГ-ний хугацаа дууссан, төслийн үр ашиг буурсан, Монгол Улсын эрх ашиг хөндөгдөж байхад арга хэмжээ аваагүй, БХГ-ний дагуу төлөх төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлэх хугацааг хоцроосон Гэрээлэгч болон АМГТГ-т зохих хариуцлага тооцоогүй, өртөг нөхөгдөх зардлыг баталгаажуулах журам, аргачлал байхгүйгээс (2019 он хүртэл) гэрээлэгчид өртөг нөхөгдөх зардлыг илүү бүртгэдэг, өртөг нөхөгдөх зардлыг бодитой тооцоход бэрхшээлтэй, БХГ-ний дагуу өртөг нөхөгдөх зардалд хийсэн хяналт үр дүнгүй зөвхөн Гэрээлэгч талын гаргасан тооцооллоор бүтээгдэхүүн хувааж байхад холбогдох дүрэм журмыг яаралтай гаргаж, мөрдүүлээгүй байна. УУХҮЯ нь газрын тосны салбарын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлснээс аудитаар өгсөн зөвлөмж хэрэгжихгүй, алдаа зөрчил давтагдсаар байна.

4. Засгийн газар болон холбогдох төрийн байгууллагууд: Гэрээлэгчид санхүүгийн тайлагналдаа олон улсын стандарт мөрдөхгүй, үндсэн үйл ажиллагаатай холбоотой ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд иж бүрэн тусгаагүй зөрчилд Сангийн яам хяналт тавиагүй, Газрын тосны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавиагүй, төлөвлөгөө, төсөв батлуулаагүй, үйл ажиллагаа явуулаагүй гэрээлэгчдийн асуудлыг нэгдсэн журмаар шийдвэрлээгүй, БХГ-г шинэчлэх тогтоолын хэрэгжилтийг хангуулах хяналт зохицуулалтын арга хэмжээг аваагүй, БХГ-ний үндсэн оролцогч талын хувиар гэрээлэгчийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийн хүрээнд УУХҮЯ болон АМГТГ-т үүрэг, чиглэл өгч, үр дүнг зохих ёсоор тооцож

ажиллаагүй, БХГ-ний дагуу олборлосон гэрээт түүхий тосыг дотоодын зах зээлд борлуулах, нийлүүлэх талаар болон АМГТГ-аас Гэрээлэгчдийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, санхүүгийн хяналт шалгалтын тайланг хүлээн авч үнэлэх УУХҮЯ болон төрийн аудитын байгууллагад хүргүүлэх хугацааг тус тус цагалбартай болгох эрх зүйн зохицуулалтыг бий болгох талаар аудитын байгууллагаас удаа дараа хүргүүлсэн зөвлөмж, албан шаардлагыг биелүүлээгүйгээс зөрчил үүсэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Дээрх зөрчлүүдээс гадна АМГТГ-аас хийсэн гэрээлэгчдийн өртөг нөхөгдөх зардлын санхүүгийн хяналт шалгалтын дүгнэлт, санал, төрийн аудитын байгууллагын өртөг нөхөгдөх зардлын тулган баталгаажуулалтын дүн аудит тус бүрээр зөрж байгаа нь мөн анхаарал татаж байна. Судалгаанд талуудын байр суурийг тэнцүү оруулах үүднээс төрийн аудитын байгууллагаас 2023 оны 12 сард баталгаажуулалт хийсэн “Газрын тосны салбарт БХГ-ээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан Гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудит” буюу Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн 2019-2021 оны аудитын тайлангаас АМГТГ-ын санхүүгийн хяналт, шалгалтын дүгнэлт, тайлангийн үзүүлэлтийг харьцуулж үзвэл:

АМГТГ-аас “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн 2019-2022 оны батлагдсан төлөвлөгөө төсвийн дагуу гүйцэтгэсэн ажлын хяналт шалгалтын дүгнэлт, тайланг дараах байдалтай ирүүлсэн байна (Хүснэгт 5).

Хүснэгт 5. АМГТГ-аас ирүүлсэн дүгнэлт, тайлангийн үзүүлэлт (тайлангийн 14-р хуудас)

№	Хянан шалгаж дүгнэлт тайлан ирүүлэх үзүүлэлт	Анхан шатны баримтад үндэслэсэн эсэх	Бүрэн хянаж дүгнэсэн эсэх	АМГТГ-аас ирүүлсэн тайлан дүгнэлтийг хянаж үзэхэд
1	Батлагдсан төлөвлөгөө, гүйцэтгэл	Тийм	Дутуу	Гэрээлэгч 2019-2021 онд нийт 1,016.9 сая ам.долларын төсөв батлуулсан. Төлөвлөгөөт ажлын гүйцэтгэлийг тоо хэмжээгээр ажил тус бүрээр гаргасан. Төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэлд үүссэн зөрүү, хийгдээгүй ажлын талаар хариуцсан мэргэжилтнүүдээс санал дүгнэлтийг хавсаргасан боловч төсвийн гүйцэтгэлийг гаргаагүй, нэгтгэж дүгнэлт тайланд тусгаагүй байна.
2	Батлагдсан төсөв, гүйцэтгэл	Тийм	Дутуу	

3	Хөрөнгө оруулалт	Үгүй	Үгүй	Хөрөнгө оруулалт, ӨНЗ-ыг хамтруулан нэг бүлэг асуудал болгон тайлагнасан. Зөвхөн ӨНЗ-ыг баримт материалтай тулгаж шалгасан тайланг ирүүлсэн. Гэрээлэгчийн 2019 оны ӨНЗ-ын хэмжээг хянасан дүгнэлтдээ 0.6 сая ам.долларын арифметик алдаатай илрүүлсэн.
4	Өртөг нөхөгдсөн зардал	Үгүй	Үгүй	
5	Нөхөгдөх зардал	Тийм	Буруу	
6	Газрын тосны экспорт	Тийм	Дутуу	
7	Борлуулалтын орлого	Тийм	Дутуу	Газрын тосны экспортын өдөр тутмын баримт, гэрээний 2 талын тооцоо нийлсэн протоколын дүн зөрүүтэй.
8	Хуваарилалт	Үгүй	Буруу	
9	Санхүүгийн тайлан	Үгүй	Үгүй	АМГТГ нь гэрээлэгчийн санхүүгийн тайланг хянан шалгаж, дүгнэлт тайлан ирүүлээгүй.

Тайланд дурдсанаар АМГТГ нь Гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажлын баримтад үндэслэн хяналт хэрэгжүүлсэн боловч санхүүгийн тайлантай тулган хянаж дүгнээгүй нь санхүүгийн тайлан үнэн зөв байх Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн заалтыг зөрчсөн байгааг дээрх хүснэгтээс харж болохоор байна. Тухайлбал, дүгнэлт гаргасан 9 үзүүлэлтээс 5 нь анхан шатны баримтад үндэслэсэн бол бүрэн хянаж дүгнэсэн үзүүлэлт байхгүй, дутуу бүрдэлтэй дөрөв, буруу дүгнэсэн үзүүлэлт хоёр, дүгнээгүй хоёр үзүүлэлт байгаа нь АМГТГ-ын санхүүгийн хяналт шалгалтын дүгнэлтийн чанар, үр дүнг илэрхийлж байна.

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ³⁶

Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулга 2014 онд батлагдсанаар газрын тосны эрэл, хайгуул болон олборлолт, ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа гэрээлэгчдийн тухайн жилийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, Гэрээлэгч болон Засгийн газрын хуваах тосны тооцоо, хуваарилалтад санхүүгийн хяналт шалгалт хийх чиг үүргийг 2019 он хүртэл Төрийн аудитын байгууллага гүйцэтгэж иржээ. Харин 2020 оны 05 дугаар сард Газрын тосны тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтөөр **газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны** байгууллага анхан шатны баримтад үндэслэн хянан шалгаж, дүгнэлт гаргасан тайлангаа төрийн аудитын байгууллагад хүргүүлэх, уг тайлан, дүгнэлтэд **Төрийн аудитын байгууллага аудит хийж баталгаажуулах** зохицуулалттай болжээ.

Санхүүгийн хяналт шалгалт хийж дүгнэлт гаргах болон түүнийг баталгаажуулах чиг үүрэг бүхий дээрх байгууллагуудын хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.

1. Хайгуулын үе шатны санхүүгийн хяналт шалгалт: Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан огнооноос тооцвол газрын тосны хайгуулын үе шатны санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөлт хуанлийн жилээс 1-3 жилээр, баталгаажуулалт 1 жилээр хоцрогдолтой буюу 2022 санхүүгийн хяналт шалгалт, түүний тулган баталгаажуулалтын аудит 2023 оны жилийн эцсийн байдлаар хийгдээгүй;

2. Олборлолтын үе шатны санхүүгийн хяналт шалгалт: Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан огнооноос тооцвол:

- Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн “БХГ-97” талбайн 2019-2022 оны аудитыг гүйцэтгэх төлөвлөлт хуанлийн жилээс дөрвөн жилээр хоцорсон байна. Энэ нь 1) 2014-2018 оныг хамарсан аудитын тайлангаар өгсөн албан шаардлагатай маргаж, гурван шатны шүүхээр маргааныг шийдвэрлүүлэх явцад хугацааг түдгэлзүүлсэн,³⁷ 2) АМГТГ-аас хяналт шалгалтын дүгнэлт, тайланг ирүүлээгүйгээс шалтгаалжээ.

36 Энэхүү дүгнэлт, зөвлөмж нь зөвхөн хувь судлаачийн байр суурийг илэрхийлж байгаа болно.

37 Уг шүүхийн маргаан 2023.03 сард эцэслэн шийдвэрлэгдэж, YAГ-ын албан шаардлагыг хэвээр үлдээсэн байна.Эх сурвалж: YAГ-ын 2023 оны 01\1132 тоот албан бичиг

- Петро Матад ХХК-ийн (Матад ХХ) талбайн хяналт шалгалтын дүгнэлт, тайланг АМГТГ-аас ирүүлээгүйгээс хуанлийн жилээс нэг жилийн хоцрогдолтой буюу 2022 оны санхүүгийн хяналт шалгалт, түүний баталгаажуулалтын аудит хийгдээгүй байна.
- Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн Тосон-Уул (ХИХ), Тамсаг (ХХИ) талбайн хувьд хуанлийн жилээс нэг жилийн хоцрогдолтой буюу 2022 оны санхүүгийн хяналт шалгалт, түүний баталгаажуулалтын аудит хийгдээгүй байдалтай байна.
- Түүнчлэн Петрочайна Дачин Тамсаг ХХК 2019-2021 оны газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд хамаарах ажил, гүйлгээг санхүүгийн тайланд иж бүрэн, үнэн зөв тусгаж тайлагнаагүй, АМГТГ хянаж, шалгаж дүгнээгүй нь БХГ, Газрын тосны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд, бүртгэлийн стандартыг зөрчсөн учир өртөг нөхөгдөх зардал болох нөхсөн зардлын дүнг төрийн аудитын байгууллага баталгаажуулахаас татгалзсан байдалтай байна.

Мөн Газрын тосны тухай хуульд 2020 онд орсон өөрчлөлтөөр газрын тосны санхүүгийн хяналт шалгалтыг хоёр үе шаттай болгосон эрх зүйн зохицуулалтын үр дүнг нэмэгдүүлэхийн тулд цаашид нарийвчлах шаардлага байсаар байна. Үүнд:

1. АМГТГ Гэрээлэгчээс дараа оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлсэн санхүүгийн тайланд хяналт шалгалт хийж, төрийн аудитын байгууллагад ямар хугацаанд хүргүүлэх нь тодорхойгүйгээс АМГТГ-ын дүгнэлт хоцордог, түүнээс шалтгаалж, тухайн онд гүйцэтгэх аудитын сэдэвт тусган батлуулахад хүндрэл үүсэж аудитын хугацаа хойшлон гүйцэтгэл он дамждаг байна.
2. АМГТГ-аас ирүүлж байгаа санхүүгийн хяналт шалгалтын дүгнэлт Нягтлан бодох бүртгэлийн тухай, Газрын тосны тухай хуулиуд болон газрын тосны бүртгэл, тооцооны журам зэрэг холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгоогүй, гэрээлэгчийн санхүүгийн тайлантай уялдуулж хянадаггүйгээс тайлан үнэн зөв, алдаагүй илэрхийлэгдсэн байх шаардлагыг хангахгүй, аудитын байгууллагад алдаатай буруу илэрхийлсэн дүгнэлт ирүүлж, аудитын эрсдэлийг нэмэгдүүлдэг байна.³⁸

Дээрх нөхцөл байдалд тулгуурлан дүгнэвэл, манай улс газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа гэрээлэгчдийн өртөг нөхөгдөх болон нөхөх зардалд хяналт бүрэн тавьж чадахгүй, 2 үе шаттай санхүүгийн

³⁸ Аудитын эрсдэл гэж санхүүгийн тайлангийн материаллаг алдааг, гажуудалтай холбоотой мэдээлэлд аудитор бодит байдалд нийцээгүй дүгнэлт өгч болох магадлалыг хэлнэ.

хяналт шалгалт нь төдийлөн үр нөлөөтэй бус байна гэж судлаачийн зүгээс үзэж байна.

Иймд Газрын тосны тухай хуульд зохих өөрчлөлт оруулж, БХГ-ний дагуу хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа Гэрээлэгчдийн өртөг нөхөгдөх болон нөхөх зардлын хэмжээг тулган баталгаажуулах эрхийг төрийн аудитын байгууллага дангаар хэрэгжүүлэх зохицуулалтыг буцаан сэргээх нь зүйтэй байна. Энэ нь дараах ач холбогдолтой. Үүнд:

1. Хугацааны хоцрогдол гарахгүй. Энэ нь зөвхөн санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөлт, гүйцэтгэлд хамааралтай биш юм. Өөрөөр хэлбэл, АМГТГ-аас гаргасан өртөг нөхөгдөх болон нөхөх зардлын дүгнэлт, санал, төрийн аудитын байгууллагын гаргасан тулган баталгаажуулалтын дүн, аудитын албан шаардлага, төлбөрийн актыг Гэрээлэгч хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргах эрхтэй тул олон үе шаттай байх тусам хяналт шалгалтын төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнг баталгаажуулахад хүндрэл үүсгэж байна.
2. Монгол Улсын Засгийн газар өөрт ногдох ашигт тосны хуваалтад хяналт тавих эрхээ хэрэгжүүлэх боломж нэмэгдэнэ. АМГТГ-аас хийж байгаа санхүүгийн хяналт шалгалт Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа татвар, нягтлан бодох бүртгэлийн стандартыг хангаж чадахгүй (бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц болон бусад хүчин зүйлсээс хамаарч) байгаа нь Гэрээлэгчид давуу байдал үүсгэж, аудитын эрсдэлийг нэмэгдүүлдэг. Энэ нь цаашид Монгол Улс газрын тосны салбарт хяналт тавьж чадахгүй байх эрсдэлийг үүсгэж байгааг Петровича Дачин Тамсаг ХХК-ийн 2019-2021 оны өртөг нөхөгдөх болон өртөг нөхсөн зардлыг аудитын байгууллага баталгаажуулахаас татгалзсан явдал батлан харуулж байна.
3. Олон нийтийн хяналтыг газрын тосны салбарт чиглүүлэх боломжтой болно. Одоо мөрдөж байгаа эрх зүйн зохицуулалтын хүрээнд АМГТГ-аас хийж байгаа санхүүгийн хяналт, шалгалтын дүгнэлт, санал нь эцэслэгдээгүй байдаг тул төрийн аудитын байгууллагад хүргүүлээгүй, аудитын тайлан гараагүй зэрэг шалтгаанаар олон нийтэд мэдээлэх үүргээ Гэрээлэгч болон АМГТГ аль аль нь хэрэгжүүлдэггүй байна. Төрийн аудитын байгууллагын тулган баталгаажуулалт болон албан шаардлага, төлбөрийн акт нь захиргааны акт бөгөөд хүчин төгөлдөр болох хугацаа, захиргааны актын шийдвэр гүйцэтгэл нь Захиргааны ерөнхий хуулиар зохицуулагдах тул газрын тосны баялгийн засаглал, хяналтад иргэд олон нийт, иргэний нийгмийн байгууллагуудыг оролцуулах боломж бүрдэнэ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ:

Монгол Улсын хууль тогтоомжууд:

1. Монгол Улсын Үндсэн хууль (1992)
2. БНМАУ-ын Газрын тосны тухай хууль УБ., (1991)
3. БНМАУ-ын Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журам (1992)
4. Төрийн аудитын тухай хууль (2020)
5. Газрын тосны тухай хууль (2014)
6. Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого /2018-2027/
7. Газрын тосны бүртгэл тооцооны журам, Засгийн газрын 2019 оны 178 дугаар тогтоолын хавсралт

Төрийн аудитын байгууллагын аудитын тайлангууд:

- Газрын тосны тухай хуулийн хэрэгжилт, төлбөр тооцооны байдалд хийсэн аудит (2015);
- Газрын тосны 2015, 2016 оны хайгуулын ажлын өртөг нөхөгдөх зардлыг баталгаажуулах аудит;
- Газрын тосны салбарт БХГ-ээр 2017-2018 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлыг хянаж, баталгаажуулах аудит;
- Газрын тосны салбарт БХГ-ээр 2019-2020 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардлыг баталгаажуулах аудит;
- Газрын тосны салбарт БХГ-ээр 2020-2021 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардлыг баталгаажуулах аудит;
- Газрын тосны салбарт БХГ-ээр олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа “Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн (БХГ-97) талбайн 2014 оны хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон өртөг нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийсэн аудит;
- Газрын тосны салбарт БХГ-ээр олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа “Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн “БХГ-97” талбайн 2015-2018 оны хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон өртөг нөхөгдөх зардлын хэмжээ,

газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийсэн аудит;

–“Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийсэн аудит;

–Газрын тосны салбарт БХГ-ээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудит (2019-2021).

Цахим эх сурвалж:

1. www.legalinfo.mn
2. www.audit.mn
3. www.mrpam.gov.mn
4. www.ereports.eitimongolia.mn
5. www.iltodgeree.mn

ХАВСРААЛ

ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРТ БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН МЭДЭЭЛЭЛ³⁹

д/д	Талбайн нэр	БХГ батлагдсан огноо	Гэрээлэгчийн нэр	Хөрөнгө оруулагчийн харьяалал
1	Тосон-Уул XIX	1993.04.26-нд байгуулсан.	Дачин Ойл Фийлд Лимитед	БНХАУ
	Буйр XXII	1993.03.29-нд байгуулсан. Дуусгавар болсон.		
	Тамсаг XXI	1996.08.07, ЗГ-ын тогтоол №183		
2.	1997 оны гэрээт	1997.02.19, ЗГ-ын тогтоол №47	Доншен газрын тос компани	БНХАУ
3.	Матад XX	2006.07.19, ЗГ-ын тогтоол №170	ПетроМатад ХХК	Монгол Улс
4.	Нялга XVI	2007.06.20, ЗГ-ын тогтоол №148	Шаман Ресурсес Лимитед	Канад
5.	Цагаан-Элс XIII	2009.05.20, ЗГ-ын тогтоол №148	DWM Петролеум AG	Швейцарь Улс
	Зүүнбаян XIV			
6.	Галба XI	2009.05.20, ЗГ-ын тогтоол №147	Зон Хэн Юу Тиан Лимитед	БНХАУ
7.	Сулинхээр XXIII	2009.07.22, ЗГ-ын тогтоол №224	Шунхлай энерги ХХК	Монгол Улс
8.	Борзон VII	2014.08.20, ЗГ-ын тогтоол №265	Импайргаз Монголиа ХХК	БНХАУ
9.	Хөх нуур XVIII	2009.07.29, ЗГ-ын тогтоол №238	Эн Пи Ай ХХК	БНХАУ
10	Төхөм X (хойд)	2009.07.29, ЗГ-ын тогтоол №237	Сансарын геологи хайгуул ХХК	БНХАУ
	Цайдам XXVI	2009.07.29, ЗГ-ын тогтоол №235		
11	Богд IV	2009.07.29, ЗГ-ын тогтоол №235	Сэнтрал Азиан Петролиум корпорэйшн Лимитэд	Их Британийн Каймэний арал улс
	Онги V	2009.07.29, ЗГ-ын тогтоол №235		
12.	Баянтүмэн XVII	2010.12.08, ЗГ-ын тогтоол №316	Магнай трейд ХХК	Монгол Улс

39 www.mrpm.gov.mn

д/д	Талбайн нэр	БХГ батлагдсан огноо	Гэрээлэгчийн нэр	Хөрөнгө оруулагчийн харьяалал
13.	Дарьганга ХХIV	2011.02.09, ЗГ-ын тогтоол №39	Апекспро инвестмент Лтд ХХК	БНХАУ
14.	Төхөм Х(урд)	2012.07.25, ЗГ-ын тогтоол №253	Монголын алт ХХК	Монгол Улс
15.	Сүхбаатар ХХVII	2013.01.05, ЗГ-ын тогтоол №02	Вульф петролеум ХК	Австрали Улс
16.	Номгон IX	2014.02.07, ЗГ-ын тогтоол №31	Сансарын геологи хайгуул ХХК	БНХАУ
17.	Увс I	2015.04.20 ЗГ-ын тогтоол №162	Монголиа Гладвилл Увс Петролиум ХХК	БНХАУ
18.	Хэрлэн-Тохой ХХVIII	2015.04.20 ЗГ-ын тогтоол №162	Хонгконг Велпек Индастриал ХХК	БНХАУ
19.	Хар-Ус II	2015.06.15 ЗГ-ын тогтоол №246	Ренова илч ХХК	БНХАУ
20.	Арбулаг ХХIX	2016.06.20 ЗГ-ын тогтоол №337	Макс Ойл ХХК	Монгол Улс
21.	Эргэл XII	2016.08.24 ЗГ-ын тогтоол №53	Smart Oil Investment ХХК	БНХАУ

Тайлбар: Дээрх хүснэгтийн 1-2 дугаартай мөрөнд газрын тосны олборлолт явуулж байгаа гэрээлэгчдийн, 3-21 дугаартай мөрөнд газрын тосны эрэл, хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа гэрээлэгчдийн мэдээлэл тус тус агуулагдсан болно.